


# ЖИЛИЙН ТАЙЛАН 2023/2024



Хараат бус

Чанар

Үр нөлөө

## IRIM судалгааны хүрээлэн

---



301, Бага тойруу, 6-р хороо, Сүхбаатар дүүрэг, 14200,  
Улаанбаатар хот, Монгол



46A/265 Улаанбаатар, Монгол



[www.irim.mn](http://www.irim.mn)



IRIMongolia



[irim\\_mongolia](https://twitter.com/irim_mongolia)



[irim\\_mongolia](https://www.instagram.com/irim_mongolia)



+976-7011-7101



[contact@irim.mn](mailto:contact@irim.mn)

ННА 60  
ДАА 300  
Ж-705

ISBN 978-9919-0-2656-1

# АГУУЛГА

## Бүлэг 1

<b>IRIM 2023 ОНД.....</b>	<b>3</b>
---------------------------	----------

1

<b>Өмнөх үг .....</b>	<b>4</b>
-----------------------	----------

2

<b>Бидний тухай .....</b>	<b>5</b>
---------------------------	----------

3

<b>Бидний үзүүлдэг үйлчилгээ .....</b>	<b>5</b>
--	----------

4

<b>IRIM тоогоор .....</b>	<b>7</b>
---------------------------	----------

5

<b>2023 оны онцлох мэдээ .....</b>	<b>9</b>
------------------------------------	----------

## Бүлэг 2

<b>IRIM-ИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД.....</b>	<b>17</b>
--	-----------

1

<b>IRIM-ийн брэнд төслүүд .....</b>	<b>18</b>
-------------------------------------	-----------

1. Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын индекс 2023 .....	18
2. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшигт өртсөн иргэдийн сайн сайхан байдал 2022-2023.....	21

2

<b>Засаглал .....</b>	<b>24</b>
-----------------------	-----------

3. Монгол Улсад тайван замаар жагсаал, цуглаан хийх эрхийг бэхжүүлэх нь .....	26
4. Олон нийтийн санал бодлын судалгаа 2024 .....	28

3

<b>Хүртээмжтэй эдийн засаг ба зохистой хөдөлмөр эрхлэлт .....</b>	<b>30</b>
---	-----------

5. Тойрог эдийн засаг ба ногоон бизнесийн чиглэлд бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах зөвлөх үйлчилгээ.....	32
6. Жижиг дунд бизнесүүдийн өрсөлдөх чадварын судалгаа .....	34
7. Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөрийн зах зээлийн судалгаа .....	36
8. “Эдийн засгийн ногоон шилжилт” төслийн суурь судалгааны мэдээлэл цуглуулалт гүйцэтгэх зөвлөх үйлчилгээ .....	38
9. Хөрөнгө оруулагчдад шаардлагатай үйлчилгээ, үйл ажиллагаа цар хүрээ, дэмжлэгийн хэрэгцээг тодорхойлох судалгаа .....	39

4

<b>Хяналт-шинжилгээ, үнэлгээ .....</b>	<b>40</b>
--	-----------

10. Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 5-р шатны хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт хийх зөвлөх үйлчилгээ.....	42
11. Усны талаарх санал бодлын судалгаа .....	44
12. “Тогтвортой хөгжлийн корпус” төслийн эцсийн шатны үнэлгээ .....	46
13. “Монгол Улс дахь ядуурлыг бууруулахад чиглэсэн хөгжлийн ажилд зөвлөгөө өгөх жижиг төслүүдийг дэмжих сан” төслийн эцсийн шатны үнэлгээ.....	48

5

<b>Уур амьсгалын өөрчлөлт ба тогтвортой байдал.....</b>	<b>50</b>
---	-----------

14. Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтийн хүний эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ .....	52
15. Орон нутгийн иргэдтэй утга учиртай харилцаа холбоо тогтоох арга зүйн сургалт ..	54
16. Экологийн цагдаа болон байгаль хамгаалагч нарын давтан сургалтад КАР анализ хийх судалгаа .....	55

6

<b>Хөгжил .....</b>	<b>56</b>
---------------------	-----------

17. Говийн Оюу Хөгжлийг дэмжих сангийн 2024-2028 оны Стратеги боловсруулах зөвлөх үйлчилгээ .....	58
18. Зудын үе дэх жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа.....	61
19. Компаниудын нийгмийн хариуцлага ба эмэгтэйчүүдийн эрх.....	64



IRIM  
INDEPENDENT  
RESEARCH  
INSTITUTE OF  
MONGOLIA

QUALITY  
Бүлэг 1

# IRIM 2023 ОНД

IMPACT

- Өмнөх үг
- Бидний тухай
- Бидний үзүүлдэг үйлчилгээ
- IRIM тоогоор
- 2023 оны онцлох мэдээ

## ӨМНӨХ ҮГ



Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд, IRIM-ийн Ерөнхийлөгч

**Х.Бэхбат**



Гүйцэтгэх захирал

**Л.Цэлмэгсайхан**

Хүндэт анд найзууд, хамтран зүтгэгчдээ,

IRIM нь 2030 он гэхэд улс орныхоо болон бүс нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулдаг **сайн засаглал бүхий, нэр хүндтэй төв** болох эрхэм зорилготой ажиллаж байна.

Бидний 2024-2030 он хүртэлх шинэ стратеги ерөнхий чиглэл нь **давуу талаа бэхжүүлэн хөгжүүлж, гадаад боломжийг ашиглан тэлэх** юм. Үүний тулд, нийгмийн судалгаа, нөлөөллийн үнэлгээ зэрэг үндсэн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийн зэрэгцээ, **уур амьсгалын өөрчлөлтийн тулгамдсан асуудлыг** шийдвэрлэхэд онцгой анхаарна.

Бид эрч хүч, эрдэм мэдлэг, эерэг үзэл санааг илтгэх **УЛБАР ШАР**, хараат бус, мэргэжлийн, ил тод хариуцлагатай байдлыг илтгэх **ХӨХ** өнгөөр өөрсдийгөө тодорхойлж ирсэн. Өнөөдрөөс бид эх дэлхий, энэрэл хайр, тогтвортой байдлын төлөө тууштай байхаа илэрхийлж **НОГООН** өнгийг өөрсдийн мөн чанартаа нэмж байна.

Ногоон хөгжлийн зүгт анхаарлаа хандуулах нь зайлшгүй байна. Монгол Улсад сүүлийн 70 жилийн хугацаанд агаарын дундаж температур 2.5 градусаар нэмэгдэж, байгалийн гамшигт үзэгдлийн давтамж, цар хүрээ өдөр тутам мэдрэгдэж эхэллээ. Энэ нь КОВИД-19-ийн сургамжтай хавсран цаашид бид түүхий эд, нөөцийг ариг гамтай ашиглах, байгальд ээлтэйгээр зохицон амьдрах, тогтвортойгоор хөгжих замыг сонгох шаардлагатай байна.

Үе хоорондын шударга, эрх тэгш байдал нь зөвхөн ёс суртахууны шаардлага биш, харин стратеги болоод байна. Бидний өнөөдрийн үйл ажиллагаа хойч үедээ баялгийн шударга хуваарилалтыг баталгаажуулж, байгаль орчныг хамгаалж, энх тайван ирээдүйг үлдээх

ёстой. Өнгөрсөн оны НҮБ-ын дээд түвшний COP28 уулзалт нь эрчим хүчний шилжилтийн хойшлуулшгүй байдал, түүнд нийгмийн бүлгүүдийн оролцоо, хүртээмжтэй байдлыг онцолсон. Манай улс ч мөн тогтвортой хөгжлийн зорилтод нийцүүлсэн, үндэсний ногоон хөдөлгөөний санаачилга, амлалтуудаа өгсөн.

Уур амьсгалын өөрчлөлт, эргэлтийн эдийн засаг, GEDSI, нийгмийн сайн сайхан байдлын чиглэлээр хийсэн бидний судалгаа, хамтын ажиллагаа нь өөрчлөлтөд хувь нэмэр оруулж байна. 2023 оны сүүлээр бид **“Уур амьсгалд тэсвэртэй хөгжлийн чиглэлээр мэргэшсэн, идэвхтэй судлаачдын бүлэг”** байгуулах санаачилгаа зарласан. Энэхүү санаачилга нь мэргэжилтнүүд, судлаачид 1) тогтмол мэдлэг, мэдээлэл хуваалцах уулзалт, 2) бодлогын болон олон нийтийн нөлөөллийн ажлууд, 3) чадавх бэхжүүлэх сургалтаар дамжуулан уур амьсгалд тэсвэртэй хөгжилд хувь нэмрээ **оруулдаг хамтын ажиллагааны платформ** юм.

Тогтвортой байдлын төлөөх зүтгэлийнхээ нэг хэсэг болгон бид **ногоон ажлын байрны алхмуудыг** идэвхтэй хэрэгжүүлдэг. IRIM нь аливаа арга хэмжээнээс үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг тооцож, улмаар дахин боловсруулалт, байгальд ээлтэй худалдан авалт, эрчим хүчний хэрэглээг бууруулах замаар байгууллагынхаа тогтвортой байдлын соёлыг төлөвшүүлдэг.

Бид өөрсдийгөө тодорхойлогч **Хараат бус, Чанар, Үр нөлөө** гэсэн үндсэн зарчмуудаа тууштай баримталж Монгол улсын хөгжлийн асуудлаар дуу хоолойгоо хүргэсээр байх болно. Тогтвортой ирээдүйн төлөөх энэхүү гайхалтай аялыг дэмжиж, хөл нийлүүлэн яваа та бүхэнд талархлаа.

2024 оны 4 сарын 04

## БИДНИЙ ТУХАЙ

Монгол Улсад судалгааны салбар дахь **хараат бус** зарчмыг түгээн дэлгэрүүлэх, төр засгийн шийдвэр гаргалтыг нотолгоо, мэдээлэлд суурилдаг болгох хүсэл зорилгоор их сургуулийн багш, шавь нийлсэн дөрвөн хүн Хараат судалгааны хүрээлэнг 2008 онд хамтран үүсгэн байгуулсан. Түүнээс хойш харилцагчдаа жинхэнэ **үнэ цэнийг** бий болгох зорилго өвөртлөн, судалгаа, үнэлгээний шинэлэг аргачлал, байгууллагын хүчтэй засаглалыг бүрдүүлэн ажиллаж, үүний **үр дүнд** хөгжлийн судалгаа, үнэлгээ, зөвлөх үйлчилгээний салбарт тэргүүлэн ажиллаж байна.

Үйл ажиллагааны цар хүрээгээ өргөжин тэлэх зорилгоор 2013 онд MIRIM Консалтант (Marketing and Innovation Research Institute of Mongolia) компанийг үүсгэн байгуулж маркетинг, инновацын судалгааны чиглэлээр мөн үйл ажиллагаа явуулж байна. Үүний зэрэгцээ Зүүн Өмнөд болон Төв Азийн улс орнуудад судалгаа шинжилгээ, зөвлөх үйлчилгээ үзүүлэн олон улсад үйл ажиллагаагаа тэлсээр байна.

### БИДНИЙ ҮЗҮҮЛДЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

**СУДАЛГАА:** Судалгаагаар дамжуулан нийгмийн олон талт бүлэгт хүрч, тэдний дуу хоолойг шийдвэр гаргалтад хүргэхийг зорин, төсөл хөтөлбөрүүдийн интервенцэд дэмжлэг үзүүлэх, судалгааны үр нөлөөг нэмэгдүүлэх зэрэг анхааран ажиллаж байна. Бидний нийт хэрэгжүүлсэн төслийн 50 орчим хувийг судалгааны төслүүд эзэлдэг.

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ:** Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь бидний хамгийн чадавх бүхий, үндсэн үйлчилгээний нэг юм. Бусад төслүүдээс ялгаатай нь ХШҮ-ний төслийг хэрэгжүүлэхэд хараат бус, хөндлөнгийн байр сууринаас, баримт нотолгоонд бүрэн суурилж, найдвартай, мэргэжлийн үнэлэлт дүгнэлт гаргахыг зорьж ажилладаг. ХШҮ-ний төслүүд бидний нийт хэрэгжүүлсэн төслийн 30 гаруй хувийг эзэлдэг.

**ТӨСЛИЙН МЕНЕЖМЕНТ:** Зөвлөх үйлчилгээний төрлүүдэд хувь хүн болон байгууллагыг чадавхжуулахаас эхлээд олон улсын хөгжлийн хөтөлбөр болон төрийн байгууллагын шийдвэр гаргагчдад нөлөөлөх бодлогын түвшинд хүртэл хүрч ажиллах зэрэг өргөн хүрээний үйл ажиллагаанууд багтдаг. Бидний нийт хэрэгжүүлсэн төслийн 10 гаруй хувийг зөвлөх үйлчилгээний төсөл эзэлдэг.

**СУРГАЛТ:** Бид өөрсдийн үйл ажиллагаа, мэдлэг туршлагадаа тулгуурлан харилцагч, захиалагч байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих болон сайжруулахад чиглэсэн сургалтын үйлчилгээг үзүүлж байна. Бид сургалтын хөтөлбөр, концепцийг харилцагч бүрийн хэрэгцээ, зорилгод нийцүүлэн боловсруулдаг тул сургалтын үр дүн, өгөөж, оролцогчдын сэтгэл ханамжийг тогтмол өндөр түвшинд хангаж чаддаг. Өөрсдийн хуримтлуулсан мэдлэг, туршлагадаа тулгуурлан харилцагч хамтрагч байгууллагуудын судалгааны ур чадвар, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.



Бид мэдлэгийн төв, нийгмийн өөрчлөлтийг хөтөлгөч байна.

# АЛСЫН ХАРАА

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн, мэргэжлийн түвшний хараат бус бүтээгдэхүүн үйлчилгээгээ үзүүлж, тогтвортой хөгжилд хөтөлгөч, тасралтгүй хөгжих мэдлэгийн төв байна.

## ҮНЭТ ЗҮЙЛС

### ХАРААТ БУС

Бид өөрсдийн үйл ажиллагааг аливаа шашин, улс төрөөс ангид байлгахыг нэн тэргүүнд тавьдаг. Үүнийг хангахын тулд бид өөрсдийн мэдээллийг ил тод байлгаж тогтмол хөндлөнгийн аудит хийлгэдэг.



### ЧАНАР

Бид байгууллагынхаа бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг хангах зорилгоор байгууллагын (ISO9001:2015) чанарын бодлогыг тасралтгүй хэрэгжүүлж, түүний дагуу сайжруулах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлдэг.



### ҮР НӨЛӨӨ

Бид өөрсдийн хэрэгжүүлж буй аливаа үйл ажиллагааг улс орны нэн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд нь хувь нэмэр оруулах, эерэг үр нөлөөг бий болгоход нэн тэргүүнд анхаарч ажилладаг.



## ISO ЧАНАРЫН БОДЛОГО

Олон улсын стандарт, захиалагчийн хэрэгцээнд нийцсэн, хараат бус судалгааны үйлчилгээ үзүүлдэг, тогтвортой хөгжих байгууллага байна.



# IRIM ТООГООР

НИЙТ  
**312**  
төсөл



**2008** ОНЫ  
4 сар

**2024** ОНЫ  
4 сар



**225,205**  
Респондент



**110**  
Захиалагч



**161**  
Хамтрагч

## Салбараар

**107**  
Засаглал

**38**  
Хүртэмжтэй эдийн засаг ба зохиистой хөдөлмөр эрхлэлт

**60**  
Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой байдал

**147**  
Хөгжил

## Үйлчилгээний чиглэлээр

**111**  
Хяналт-шинжилгээ, үнэлгээ

**153**  
Судалгаа

**28**  
Төслийн менежмент

**20**  
Сургалт

## ГАЗАР ЗҮЙН ТУРШЛАГА

Хэрэгжүүлсэн төслийн тоо

### ТӨВ АЗИ

- 2 Афганистан
- 2 Казакстан
- 2 Киргизстан
- 1 Пакистан
- 1 Шри-Ланка
- 2 Тажикистан
- 1 Туркменистан
- 1 Узбекистан

### МОНГОЛ

- 47 Архангай
- 42 Баян-Өлгий
- 55 Баянхонгор
- 31 Булган
- 50 Говь-Алтай
- 30 Говьсүмбэр
- 55 Дархан-Уул
- 53 Дорнод
- 45 Дорноговь
- 51 Завхан
- 42 Орхон
- 66 Өмнөговь
- 54 Өвөрхангай
- 49 Увс
- 38 Сүхбаатар
- 54 Сэлэнгэ
- 47 Төв
- 68 Ховд
- 60 Хөвсгөл
- 49 Хэнтий
- 208 Улаанбаатар

### ЗҮҮН ӨМНӨД АЗИ

- 1 БНХАУ-ын Эрээн хот
- 1 Зүүн-Тимор
- 1 Бангладеш

## ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУД

### ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА



### ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА



### АКАДЕМИК БАЙГУУЛЛАГА



### ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА



### ХУВИЙН ХЭВШЛИЙН БАЙГУУЛЛАГА



## 2023 ОНЫ ОНЦЛОХ МЭДЭЭ

### IRIM СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН 2024-2030 ОНЫ ШИНЭ СТРАТЕГИ БАТАЛЛАА

IRIM судалгааны хүрээлэн нь хувьсан өөрчлөгдөж буй хөгжлийн шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаагаа бэхжүүлэх стратегийн алхмаа хийж 2024-2030 онд хэрэгжүүлэх шинэ стратегиа албан ёсоор баталлаа. Энэхүү стратегийн хүрээнд 4 зорилгыг онцолсон бөгөөд үүнд байгууллагын үзүүлж буй үйлчилгээнийхээ үр нөлөөг нэмэгдүүлэх, хүний нөөцийн олон янз байдлыг дэмжих, үйлчилгээнүүддээ технологийн шинэчлэлийг бэхжүүлэх, байгууллагын дотоод сайн засаглалыг хангах зэрэг зорилгууд багтана. Улмаар бид энэхүү цогц стратегид тусгагдсан дараах 4 зорилгоор дамжуулан даян дэлхийн *Тогтвортой хөгжлийн зорилт-2030*-д хувь нэмрээ оруулахаар зорин ажиллана.

### IRIM СТРАТЕГИ 2030



#### ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ

Байгууллага нь харилцагчдын онцлог хэрэгцээг хангаж, үр нөлөөг нь дээд зэргээр дээшлүүлэхэд анхаарч байгууллагаас үзүүлж буй зөвлөх үйлчилгээгээ сайжруулахыг зорино.



#### ТЕХНОЛОГИЙН АХИЦ ДЭВШЛИЙГ НЭН ТЭРГҮҮНД НЭВТРҮҮЛЭХ

Технологийн ахиц дэвшлийг нэн тэргүүнд нэвтрүүлэхийн тулд IRIM судалгааны хүрээлэнгээс санал болгодог бүтээгдэхүүн, үйлчилгээнд нэн шинэ үеийн технологийг нэвтрүүлэхэд ихээхэн ач холбогдол өгч ажиллахаар зорьж байна. Энэхүү алхам нь ач холбогдолтой байдал, үр ашигтай байдал, өрсөлдөх чадварыг бэхжүүлэхээс гадна Монгол Улсад инновацад суурилсан хөгжлийг бий болгох замыг тавьж өгөх юм.



#### ХҮНИЙ НӨӨЦИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДЭМЖИХ

Хүний нөөцийн хөгжил нь энэхүү стратегийн гол анхаарч буй асуудал болж байгаа бөгөөд, олон янзын, тогтвортой, тасралтгүй хөгжих ажиллах хүчийг бий болгож, тасралтгүй суралцах, дасан зохицох соёлыг бэхжүүлэхэд анхаарч ажиллана.



#### БАЙГУУЛЛАГЫН САЙН ЗАСАГЛАЛЫГ БИЙ БОЛГОХ

Байгууллагын үйл ажиллагааны бүх түвшинд ил тод, хариуцлагатай, ёс зүйтэй, тогтвортой (ногоон) дадал, туршлагыг бий болгохыг зорьсон байгууллагын сайн засаглалыг бий болгох нь амин чухал зорилго болж байна.

Манай байгууллагын 2024-2030 оны стратеги нь зөвхөн бидний дотоод үйл ажиллагааны замын зураг биш бөгөөд бидний зүгээс бүс нутгийн болон үндэсний тогтвортой хөгжлийг ахиулахад оруулж буй хүчин чармайлт юм.

## МАНАЙ 11 СУДЛААЧ АВСТРАЛИЙН ГРИФФИТ ИХ СУРГУУЛЬД ТАВАН ДОЛОО ХОНОГИЙН ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДЛАА

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, түүнийг тойрсон асуудлууд дэлхий дахины анхаарлын төвд орж, бүх нийтээрээ тэсвэртэй, тогтвортой хөгжлийг бий болгоход идэвхтэй хамтран ажиллаж эхэлсэн. Манай байгууллагын хувьд ч мөн адил мэргэжлийн судалгаа, зөвлөх үйлчилгээгээр дамжуулан энэхүү нийтлэг зорилгод өөрсдийн гэсэн хувь нэмрээ оруулсаар байна.

Энэ хүрээнд 2023 онд манай байгууллагын 11 судлаач уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хөгжлийн талаарх өөрсдийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхээр Австралийн Богино хугацааны тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж, Гриффит Их Сургуульд таван долоо хоног суралцлаа. Энэхүү хугацаанд хөтөлбөрийн үндсэн сэдэв болох **“Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, жендэрийн тэгш байдлыг хангасан жижиг дунд бизнес”**-ийн хүрээнд Гриффит болон Өмнөд Квинсландийн Их Сургуулийн судлаач, профессоруудтай хамтран гурван бодлогын хураангуй болон жижиг, дунд бизнесүүдэд зориулсан уур амьсгалын өөрчлөлтөд хариу арга хэмжээ авах хэрэглэгдэхүүнүүдийг тус тус боловсруулаад байна.



Өгүүлэл тус бүрийн зураг дээр дарж дэлгэрэнгүй танилцах боломжтой.

Хөтөлбөрийн төгсгөлд IRIM судалгааны хүрээлэн тэсвэртэй хөгжлийн чиглэлээрх олон талуудыг хамруулсан, идэвхтэй хэлэлцүүлэг бүхий хурал зохион байгуулж, хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн судалгааны үр дүнгүүдийг танилцуулав. Түүнчлэн бидний зүгээс мэргэжлийн судлаачдыг оролцуулсан *“Community of Practice”* буюу уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, тогтвортой хөгжлийг бий болгоход хувь нэмрээ оруулах нийгмийн бүлгэмийг байгуулах санаачилга гарган үйл ажиллагаа эхлүүлээд байна.




## АВСТРАЛИЙН САЙН ДУРЫНХАН ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД 2023 ОНД



IRIM судалгааны хүрээлэн нь Австралийн Сайн Дурынхан Хөтөлбөртэй 2011 оноос хойш хамтран ажиллаж, байгууллагадаа сайн дурын ажилтнууд хүлээн авсаар ирсэн. Бидний олон жилийн хамтын ажиллагааны нэг хэсэг болгон, манай судалгааны хүрээлэнгийн 11 судлаач 2023 оны 9 сард Австрали улсын Брисбани хотод амьдарч буй сайн дурын ажилтнуудтай нэг өдрийн танилцах, туршлага солилцох арга хэмжээ зохион байгууллаа.

Мөн 2024 оны хувьд бид найм дахь олон улсын сайн дурын ажилтан Элоиз МакКлинтай хамтран ажиллаж байна. Тэрээр бидний цар тахлын үеэс хойш зайнаас хамтарч байгаа гурав дахь сайн дурын ажилтан бөгөөд 2024 оны 7-р сарын 15 хүртэл уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой байдлын чиглэлээр төсөл боловсруулах чадавхыг бэхжүүлэх, олон улсын шинэ түнш байгуулагатай харилцаа тогтоох замаар IRIM-ийн гадаад сүлжээг сайжруулах зорилтуудыг тавин ажиллаж байна.



## IRIM ЖИЛИЙН ХҮЛЭЭН АВАЛТААРАА УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ТЭСВЭРТЭЙ ХӨГЖЛИЙГ ОНЦОЛЛОО

2023 оны 11 дүгээр сард Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, IRIM судалгааны хүрээлэнгийн Ерөнхийлөгч Х.Бэхбатын ивээл дор “Жилийн хүлээн авалт”-аа уламжлал болгон зохион байгуулж хүндэт зочдоо хүлээн авлаа. Уг хүлээн авалт уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хөгжил сэдвийн хүрээнд зохион байгуулагдаж, IRIM болон Австралийн Гриффит Их Сургуулийн судлаачид хамтран **“Монгол Улс дахь жижиг, дунд бизнес (ЖДБ)-үүдийн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх”** асуудлаар үндсэн илтгэлүүд хэлэлцүүлсэн билээ.


Арга хэмжээний онцлох үйл явдал бол IRIM-ийн шинэ санаачилга болох “Community of Practice” нийгмийн бүлгэмийг байгуулах санаачилгыг эхлүүлсэн явдал байв. Уг санаачилгыг хэрэгжүүлэх эхний алхам болгож Монгол Улс дахь ЖДБ-үүдэд зориулж боловсруулсан **“Уур амьсгалын өөрчлөлтөд авах хариу арга хэмжээ авах хэрэглэгдэхүүн”**-ийг танилцуулж, хүрэлцэн ирсэн зочдод хүлээлгэн өглөө.

Хүлээн авалтад эрхэм элчин сайд нар, олон улсын болон төрийн байгууллагуудын төлөөлөл, зөвлөхүүдээс бүрдсэн нийт 56 гаднын зочид, төлөөлөгчдийг оролцуулан динамик хэлэлцүүлгийг өрнүүлж, хэтийн төлөв, чухал санаануудыг солилцов.

Бидний хувьд уг хүлээн авалтыг жил бүр зохион байгуулснаараа хөгжлийн олон талын түншүүдийг идэвхжүүлж, хамтын ажиллагааны түншлэлийг дэмжиж, мэдлэгийг түгээх талбар болдог төдийгүй өнөөгийн нийгэмд тулгарч буй ээдрээтэй сорилтуудыг шийдвэрлэх санаачилгуудыг манлайлж улс орны тогтвортой хөгжилд судалгаа, шинжилгээгээр дамжуулан өөрсдийн хувь нэмэр, дуу хоолойгоо хүргэх боломжийг олгодог.



## ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ISO 9001:2015 СТАНДАРТЫН МАГАДЛАН АУДИТААР ДАХИН БАТАЛГААЖЛАА



IRIM судалгааны хүрээлэн нь судалгаа, үнэлгээ, зөвлөх үйлчилгээний төслүүдээ мэргэжлийн түвшинд, чанартай гүйцэтгэж, үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулахад анхаарсаар ирсэн. Уг зорилтынхоо хүрээнд 2016 оноос хойш олон улсын Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхэлсэн бөгөөд 2022 оны 8 дугаар сард олон улсын баталгаажуулалтын гэрчилгээ, 2023 оны 5 дугаар сард магадлан аудитын гэрчилгээгээ ту тус гардан авлаа. IRIM судалгааны хүрээлэн нь “Олон улсын стандарт, захиалагчийн хэрэгцээнд нийцсэн, хараат бус судалгаа, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг, тогтвортой хөгжих байгууллага байх” чанарын бодлогоо хэрэгжүүлэн, үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулахад анхааран ажилласаар байна.

## “ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХӨТЛӨХ ЦАХИМ ТЕХНОЛОГИ” СЭДВИЙН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН CAREC-ИЙН 7 ДАХЬ ФОРУМД ОРОЛЦЛОО


CAREC Think Tank Development Forum нь CAREC Think Tank Network (CTTN)-ийн ивээл дор жил бүр зохион байгуулагддаг билээ. Жил бүр форум нь Төв Азийн бүс нутгийн судалгааны төвүүд, олон талт хөгжлийн түншүүд, засгийн газар, хувийн хэвшлийн тэргүүлэх мэргэжилтнүүдийг цуглуулж, бүс нутгийн тулгамдсан асуудлуудын талаар ярилцаж, харилцан яриа, туршлага солилцох, мэдлэгийн хамтын ажиллагаагаар дамжуулан эдгээр сорилтыг шийдвэрлэх олон талт хэтийн төлөв, шинэлэг шийдлүүдийг санал болгодог уламжлалтай. 2023 онд VII дахь удаагаа зохион байгуулагдаж буй форум нь “Байгальд ээлтэй, тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжихэд цахим технологийг нэвтрүүлэх нь” сэдвийн дор БНХАУ-ын Өрөмч хотод зохион байгуулагдсан бөгөөд IRIM нь гишүүн байгууллагын хувьд оролцоод байна.

Форумаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад дижитал технологийн үүрэг, Төв Азийн бүс нутгийн цахим технологийн шилжилтэд бэлэн байдал, цахим дэд бүтэц, бизнесийн таатай орчинд хөрөнгө оруулалт хийх, цахим худалдаа, дижитал санхүүжилтийг хөгжүүлэх, хөдөлмөрийн зах зээл, дижитал засаглал, CAREC-ийн гарааны экосистемийн боломж, сорилтуудын талаар ярилцав.



## КИРГИЗСТАН УЛСЫН БИШКЕК ХОТНОО ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ТӨВ АЗИЙН INNOVATION FOR CHANGE/I4C-ИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТИЙН УУЛЗАЛТАД ОРОЛЦОВ

IRIM судалгааны хүрээлэн нь 2018 оноос хойш I4C-тэй хамтран ажиллаж байгаа билээ. Үүний хүрээнд IRIM-ын зөвлөх Ц.Батсугар, Н.Минжирмаа болон судлаач С.Одонтуяа нар 2023 оны 7-р сарын 24-өөс 28-ны өдрүүдэд Киргизстан улсын Бишкек хотод зохион байгуулагдаж буй I4C стратеги төлөвлөлтийн уулзалтад оролцсон ба уулзалтын үеэр 2020-2021 оны хооронд I4C-тэй хамтран хэрэгжүүлсэн “Цахим Марафон” болон “Шийдэлд чиглэсэн судалгааны лаборатори” төслүүдийн үр дүнг танилцуулан туршлага хуваалцсан юм. Уулзалтын үлдсэн өдрүүдэд IRIM-ийн төлөөллүүд I4C Төв Азийн 2023-2026 он хүртэлх Стратегийн төлөвлөгөөг боловсруулахад хувь нэмрээ оруулж, саналаа хуваалцав. I4C Төв Азийн одоо байгаа 2019-2023 оны стратеги төлөвлөгөөг 2019 онд боловсруулж, 2020 онд КОВИД-19-ийн үеэр шинэчилж байв.



## НИЙГМИЙН САЙН САЙХАН БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ: МОНГОЛ, ФИЛИППИН, ВЬЕТНАМ УЛСУУД ДАХ БАЙГАЛИЙН ГАМШИГТ ТЭСВЭРТЭЙ БАЙДЛЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ 3 ЖИЛИЙН ХАМТАРСАН СУДАЛГААНЫ ЯВЦЫН ТАЙЛАН

IRIM судалгааны хүрээлэн нь 2022 оноос эхлэн 3 жилийн хугацаатай хамтарсан судалгааны төслийг эхлүүлсэн. Энэхүү санаачилга нь Японы Шинжлэх Ухааныг Сурталчлах Нийгэмлэг (JSPS)-ийн Ази-Африкийн Шинжлэх Ухааны салбарын Core-to-Core хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй мэргэжлийнхээ замналын эхэн үед явж буй залуу судлаачдад зориулсан судалгааны чадавхыг сайжруулах болон олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилго бүхий хөтөлбөрийн нэг хэсэг юм. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь нийгмийн сайн сайн байдлыг судалгаа, инновацаар дамжуулан хөгжүүлэх IRIM-н үндсэн зорилготой ихээхэн нийцэж байгаа юм.

IRIM-ын судлаачид нь Филиппин болон Вьетнамын судлаачидтай хамтран хуурай болон арлын орнуудын тэсвэртэй байдал болон нийгмийн капиталыг харьцуулан судалж, уг төсөлд ахиц гарган ажиллаж байна. Уг судалгаа нь уур амьсгалд тэсвэртэй байдалд нийгмийн капитал хэрхэн хувь нэмэр оруулдаг талаар судалж, байгалийн гамшгийн өмнө болон дараа нь олон нийтийн тэсвэртэй байдлыг бүрдүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлэхэд чиглэн ажиллаж байна. Судлаачид нь Монгол, Филиппин, Вьетнам дах олон нийтийн туршлагаудыг харьцуулан судлах замаар байгалийн гамшигтай тулгарахад олон нийтийн гамшгийг даван туулах чадавхыг сайжруулахад чиглэн хэрэгжүүлж буй стратегиуд болон сайн туршлагыг илрүүлэхийг зорьж байгаа юм.





Монгол Улсад хийгдсэн мэдээлэл цуглуулалтын ажилд IRIM-ын залуу судлаачид болох Т. Элбэрэл, Г. Жаргалмаа, Г. Билгүүнзаяа нар болон зөвлөхүүдээс Ц. Болд, Я. Бямбасүрэн нар түүчээлэн оролцлоо. Энэхүү багийнхан нь олон нийтийн гамшгийг даван туулах чадавхыг бий болгож буй хүчин зүйлсийг илрүүлэхэд шаардлагатай мэдээлэл цуглуулах ажилд ихээхэн ахиц гарган ажиллаж байна. Энэхүү хамтарсан хөтөлбөр хоёр дах жилийн зааг дээрээ ирж буй энэ цагт IRIM судалгааны хүрээлэн нь байгалийн гамшигт тэсвэртэй байдлын талаарх ойлголтыг таниулахад үргэлжлүүлэн хүчин чармайлт гаргаж ажилласаар байна.

Багийн зүгээс судалгааны талаар эерэг хүлээлтэй байгаа бөгөөд үр дүн нь Монголд нийгмийн сайн сайхан байдал болон гамшигт тэсвэртэй байдлыг бий болгоход чухал хувь нэмэр оруулна гэж найдаж байна. Энэхүү хөтөлбөрт хамрагдсанаар IRIM-ын залуу судлаачид өөрсдийн мэргэжлийн сүлжээг өргөтгөх, нийгмийн сайн сайхан байдал болон гамшгийг даван туулах талаарх ойлголтоо гүнзгийрүүлэх боломж бүрдсэн юм.

## МОНГОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ СҮЛЖЭЭ (MEN)-ИЙН ОРОЛЦОО НЬ АЗИ НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ПРАКТИКИЙГ АХИУЛНА

Ази Номхон Далайн Үнэлгээний Холбоо (APEA) 2023 оны 12-р сард Филиппин улсын Манила хотноо "APEA 4th Conference & EvalVisionAsia 2023"-ыг зохион байгууллаа. "Үнэлгээний ирээдүй: Ази Номхон далайн бүс нутагт эрх тэгш хөгжлийн төлөөх түншлэлийг хөшүүрэг болгох нь" сэдэвт энэхүү арга хэмжээ нь Ази Номхон далайн бүс нутагт хөгжлийн үнэлгээг институтчилэх стратеги, ахицын талаар хэлэлцлээ. Монголын үнэлгээний сүлжээг төлөөлөн IRIM-ийн гүйцэтгэх захирал Л.Цэлмэгсайхан, ахлах судлаач Т. Элбэрэл нар оролцож, Монгол дахь үндэсний үнэлгээний тогтолцооны институтчиллийн тухай танилцуулсан билээ. Чуулганы үеэр үнэлгээний хөгжилд томоохон ахиц дэвшил авчирсан чухал, олон талт арга хэмжээ болох Манилагийн Тунхагыг баталж, оролцогчид дэмжиж гарын үсгээ зурсныг байгааг онцлон тэмдэглэв.



Ази номхон далайн үнэлгээний сүлжээ (APEA)-ийн ТУЗ-д IRIM судалгааны хүрээлэнгийн Гүйцэтгэх захирал А.Долгион 2018-2019 онд, Ц.Батсугар 2020-2021 онд, ахлах судлаач Т.Элбэрэл 2022-2023 онд ТУЗ-ын гишүүнээр сонгогдон ажиллаж байв. Энэ удаад IRIM-ийн Гүйцэтгэх захирал Л.Цэлмэгсайхан 2024 оноос тус холбооны ТУЗ-ын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

## ДЭЛХИЙН СОЦИОЛОГИЙН ХХ ИХ ЧУУЛГАНД IRIM-ИЙН ТӨЛӨӨЛӨГЧИД ИЛТГЭЛ ТАНИЛЦУУЛАВ

Олон улсын Социологийн Холбоо (ISA)-оос зохион байгуулсан Дэлхийн социологийн ХХ чуулган Австралийн Мельбурн хотноо 2023 оны 6-р сарын 25-аас 7-р сарын 1-ний хооронд болж өнгөрлөө. Чуулганаар дэлхийн социологичид сэргэж буй авторитар дэглэм болон шашин, улс төр, эдийн



засгийн шинэ ээдрээтэй цаг үеийг ойлгоход хэрхэн хувь нэмрээ оруулах талаар хэлэлцсэн.

IRIM-ийн удирдлагууд ISA-ийн Үндэсний нийгэмлэгүүдийн зөвлөлийн гишүүний хувьд энэхүү Дэлхийн XX их чуулганд хуралд оролцсон. Гүйцэтгэх захирал Л.Цэлмэгсайхан, ТУЗ-ийн гишүүн А.Долгион, зөвлөх З.Манлайбаатар нар **“Субъектив сайн сайхан байдлын тухай Монголын төсөөлөл”**; **“Уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг байдлын үнэлгээ: Монголын жишээ”** болон **“Зүүн Тимор дахь КОВИД-19 цар тахлын үеийн субъектив сайн сайхан байдлын үнэлгээ: Үндэсний хэмжээнд хийсэн өрхийн судалгаа”** зэрэг сэдвүүдээр тус тус илтгэл танилцууллаа.



## НИЙГМИЙН САЙН САЙХАН БАЙДЛЫГ СУДЛАХ ОЛОН УЛСЫН КОНСОРЦИУМЫН 7 ДАХЬ БАГА ХУРАЛ БОЛЛОО

Нийгмийн сайн сайхан байдлыг судлах олон улсын консорциумын 7 дахь бага хурал 2023 оны 2-р сард Япон улсын Токио хотноо зохион байгуулагдав. Азийн найман орны эрдэмтэн, судлаачид оролцож, улс орон бүрийн нийгмийн сайн сайхан байдлын талаар хэлэлцүүлэг өрнүүлэв.

Тус хуралд IRIM-ийн Гүйцэтгэх захирал Л.Цэлмэгсайхан оролцож, 8 орныг хамтарсан **“Азийн хөгжиж буй орнуудад Санаачилгад тулгуурласан тэсвэртэй байдлыг бий болгоход Нийгмийн капиталыг ашиглах нь”** төслийн хүрээнд Монгол улсад 2023 онд эхлүүлж буй, “дүрс зургийн хэл” хэмээх чанарын судалгааны шинэ аргачлалаар хийх судалгааны дизайн, төлөвлөгөөг танилцууллаа. Судалгааны төсөл нь хямрал, гамшиг тохиоход урьдчилан бэлдэх, яаралтай хариу арга хэмжээ авах, дасан зохицох чадварыг бий болгоход нийгмийн капиталын үүргийг тодруулах зорилготой юм. Энэхүү судалгаа нь Зүүн өмнөд болон Зүүн Азийн хөгжиж буй орнуудын эмпирик нотолгоонд тулгуурлан нийгмийн капитал, тэсвэртэй байдлын талаарх онол болон бодит байдлын талаарх эрдэм шинжилгээний хэлэлцүүлгийг урагшлуулахад хувь нэмэр оруулах юм.



## IRIM-ИЙН ТӨЛӨӨЛӨЛ НЬУ-ЙОРК ХОТНОО ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ХӨРӨНГӨ БОСГОХ ЗАРЧИМ, АРГА ЗҮЙ СЭДЭВТ СУРГАЛТАД ХАМРАГДАЖ ӨӨРСДИЙН ТУРШЛАГАА СОЛИЛЦОВ

Гүйцэтгэх захирал Л.Цэлмэгсайхан 2023 оны 5-р сард АНУ-ын Нью-Йорк хотноо зохион байгуулагдсан “Хөрөнгө босгох зарчим, арга зүй” сэдэвт сургалтад хамрагдлаа. Зөвхөн урилгаар оролцох боломжтой энэхүү хөтөлбөр нь дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн их сургууль, судалгааны байгууллагуудын хөрөнгө босгох шилдэг туршлагын талаар суралцах, Америкийн хамгийн амжилттай явж буй хамтрагч түнш байгууллагуудтай уулзах онцгой боломжийг олгосон юм.

Сургалт нь Нью-Йорк хотын хөрөнгө босгох чиглэлээр туршлага суралцах дөрвөн өдрийн интерактив хэлэлцүүлгээс бүрдсэн. Оролцогчдод АНУ дахь их дээд сургууль, судалгааны байгууллагуудад хөрөнгө босгоход зориулсан практик хэрэглэгдэхүүнүүд болон санхүүжилтээ өргөжүүлэх бүтээлч шийдлүүдийн талаар гүнзгий мэдлэг олгосон юм.

Тус сургалтыг АНУ-ын King Baudouin Сан болон Give2Asia байгууллагууд хамтран зохион байгуулсан. IRIM судалгааны хүрээлэн нь Give2Asia олон улсын хандивын сүлжээнд 2018 онд гишүүнээр элссэн юм.



## АРДЧИЛАЛ, ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭМЖИХ НЬ: IRIM-ИЙН ХУВЬ НЭМЭР БА СУДАЛГААНЫ САНААЧИЛГУУД

Ардчилал болон иргэний орон зай, иргэний эрхийн чиглэлээр IRIM судалгааны хүрээлэн идэвхтэй ажилладаг. Ардчилал, хүний эрхийн чиглэлийн ажлуудын үр нөлөөг нэмэгдүүлэх, олон улсад таниулах, хамтын ажиллагааг бий болгох зорилгоор Азийн ардчиллын судалгааны сүлжээ (Asia Democracy Research Network)-д 2020 оноос гишүүнээр элсэн, идэвхтэй хамтран ажиллаж байна.

2023 оны 3-р сард IRIM-ийн ТУЗ-ийн гишүүн А.Долгион нь БНСУ-ын Сөүл хотноо Зүүн Азийн Хүрээлэнгээс (EAI) зохион байгуулсан Азийн Ардчиллын Судалгааны Сүлжээ (ADRN) хөтөлбөрийн 13 дахь удаагийн бүсийн семинарт оролцов. Энэ удаагийн зөвлөгөөний үеэр Долгион 2022 онд эхэлсэн судалгааны ажлын явцын үр дүнг танилцуулсан юм. Мөн түүний “Монгол дахь шууд ардчиллын түүх ба чиг хандлага” судалгааны өгүүлэл хэвлэгдээд байна.



## Бүлэг 2

# IRIM 2023 ОНД

- IRIM-ийн брэнд төслүүд
- Засаглал
- Хүртээмжтэй эдийн засаг ба зохистой хөдөлмөр эрхлэлт
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ
- Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой байдал
- Хөгжил

## IRIM-ИЙН БРЭНД ТӨСЛҮҮД

# ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫН ИНДЕКС 2023



Зураг дээр дарж дашбоардтай танилцах боломжтой.  
мэдээллийн цахим ил тод байдлыг үнэлсэн.

### ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Мэдээлэл, харилцаа, холбооны технологи (МХХТ)-ийн хэрэглээ дэлхийн нийтийг хурдацтай хамарч, засгийн газар, хувийн хэвшил, олон нийтийн болон бизнесийн уламжлалт хэв маягийг дахин хэлбэржүүлж дараагийн түвшинд хурдацтай шилжих үйл явц өрнөж байна. Энэхүү МХХТ-ын дэвшил нь иргэд, олон нийтэд орон зай, газар зүйн байршлаас үл хамааран ил тод, нээлттэй мэдээллийг цаг хором мөч алдалгүй түргэн шуурхай хүрэхэд хамгийн чухал хэрэгсэл юм.

Сүүлийн жилүүдэд МУЗГ-аас цахим засаглалыг хөгжүүлэх арга хэмжээнүүдийг идэвхжүүлж, хариуцах шинэ бүтцийг бий болгож, дагалдах зарим томоохон бодлого, арга хэмжээг шинээр батлан хэрэгжүүлж байна. 2022 онд **"Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль"**-д шинэчилсэн найруулга хийгдсэнтэй холбоотойгоор мэдээллийн цахим ил тод байдлыг хэмжих арга зүйд суурь шинэчлэлтүүдийг хийж өмнөх онд шинэ аргазүйгээр төрийн байгууллагуудын

IRIM судалгааны хүрээлэн нь цахим ил тод байдлын хөндлөнгийн үнэлгээг 12 дох жилдээ гүйцэтгэн та бүхэнд хүргэж байгаа бөгөөд мэдээллийн цахим ил тод байдлыг тогтмол сайжруулахад нь хөшүүрэг болох үндсэн зорилготойгоор хийж хэрэгжүүлсээр ирлээ.

### ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Индексийн гол зорилго нь төрийн байгууллагуудын цахим мэдээллийн ил тод байдлыг тоон үзүүлэлтээр хэмжиж, нийт үр дүнг улсын хэмжээнд тооцоолсноор цаашид засгийн газар болон төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд хөшүүрэг болоход хувь нэмэр оруулах зорилготой юм. Индексийн гол зорилтууд нь:

- Төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын түвшнийг хэмжиж, эрэмбэлэх
- Үр дүнг өмнөх жилүүдтэй харьцуулах
- Цаашид сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмж боловсруулах юм.

## ХАМРАХ ХҮРЭЭ

97 төрийн байгууллага	
16	Яам
30	Хэрэгжүүлэгч агентлаг
10	Тохируулагч агентлаг
10	Парламентын харьяа байгууллага
22	Аймаг, нийслэлийн ЗДТГ
9	Нийслэл, дүүргийн ЗДТГ

Төрийн захиргааны нийт 97 байгууллагын үр дүнд үндэслэн цахим ил тод байдлын индексийг тооцон гаргадаг.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН

Төрөөс мэдээллийг ил тод болгох үйл явц нь зөвхөн төрийн үйл ажиллагааны үр дүн бус (i) мэдээллийг ил тод болгох орчин бий эсэх, (ii) түүнийг хэрэгжүүлэх төрийн байгууллагын чадамж байгаа эсэх, (iii) үүний үр дүнд иргэд, олон нийтэд мэдээлэл бүрэн, хялбар, хүртээмжтэйгээр хүрч буй эсэх үйл явцыг үнэлдэг. Тиймээс энэхүү индексийн загвар нь гурван бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд бүрэн цогцоор нь үнэлэх оролдлого юм.

### Цахим ил тод байдлын индексийн үзэл баримтлалын хүрээ



Ихэнх индексийн адилаар индикаторуудыг нэгтгэж, цахим ил тод байдлыг илтгэх нэгдсэн нэг ноогоор хэмжигдэнэ. Эдгээр оноо нь үндэсний болон байгууллагын түвшинд илэрхийлэгдэх боломжтой байна. Цахим ил тод байдлын индексийг хэмжихийн тулд 35 шалгуур

### Тооцох аргачлал



### Индексийн түвшин


Сайн	≥ 0.80
Хангалттай	0.65-0.79
Сул	0.50-0.64
Хангалтгүй	0.35-0.49
Муу	< 0.35

үзүүлэлтийн дагуу 150 асуулт/үзүүлэлтийг ашигладаг.

Индексийн үзүүлэлтийг байгууллага бүр өөрийн давуу болон сул талыг танин мэдэхийн тулд харьцуулсан дүн шинжилгээнд тулгуурлана. Энэхүү индексийг байгууллагууд бие биеэсээ суралцах, цахим мэдээлэл түгээх чадавх болон сорилт, бэрхшээлийг тодорхойлох, энэ чиглэлийн бодлого, стратегийг тодорхойлох хэрэгсэл болгон ашиглахыг санал болгож байна.

## ҮР ДҮН

Төрийн болон орон нутгийн захиргааны зургаан төрлийн 97 төрийн байгууллагын 2023 оны цахим ил тод байдлын ерөнхий индекс 65.2% гарсан нь төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын индексийг хэмжиж эхэлснээс хойш анх удаа 'хангалттай' түвшинд үнэлэгдлээ. Уг үр дүнг 2022 онтой харьцуулахад (63.1%) бага зэрэг өссөн байгаа ч ангиллын хувьд нэг түвшин ахиж байгаа юм.



Бодлогын орчны дэд индекс 'хангалттай' (79.2%) түвшинд үнэлэгдсэн. Энэ үр дүнг 2022 оны үр дүнтэй харьцуулахад (78.8%) бага зэрэг буюу 0.4%-аар өссөн үзүүлэлт юм. Бодлогын орчинд хамаарах дэд таван бүлэг ерөнхийдөө бүгд зэрэг ахицтай үнэлэгдсэн. МУЗГ-т Цахим хөгжил, харилцаа холбооны яам байгуулагдаж тусдаа бүтэц бий болсноор төрийн байгууллагуудын цахимжилт эрчимжиж, мэдээллийг ил тод, нийтэд түргэн шуурхай түгээх байдал нэмэгдэж байна.

Байгууллагын чадамжийн дэд индекс 'хангалттай' (72.8%) түвшинд үнэлэгдсэн. Энэ нь өмнөх оны үр дүнтэй (2022 онд 66.2%) харьцуулахад мэдэгдэхүйц буюу 6.6%-аар өссөн үзүүлэлт юм. Энэ нь төрийн байгууллагын мэдээллийн цахим ил тод байдлын ерөнхий индекс сул түвшнээс хангалттай түвшинд үнэлэгдэхэд чухал нөлөө үзүүлсэн.

Мэдээллийн цахим нээлттэй байдлын дэд индекс "хангалтгүй" (47.5%) түвшинд үнэлэгдсэн.

Энэ үр дүнг 2022 оны үр дүнтэй харьцуулахад 2%-аар өссөн хэдий ч төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Бусад бүрэлдэхүүн хэсэгтэй харьцуулахад жил бүр эерэг өөрчлөлт нь бага мэдрэгдэж сул түвшинд хэвээр байна.

Байгууллагын төрлөөр үр дүн, өмнөх жилтэй харьцуулалт

#	Байгууллагын төрөл	2023 оны индекс	2022 оны индекс	Зөрүү
1	Монгол Улсын Яамд	70.7%	66.6%	4.1%
2	Хэрэгжүүлэгч агентлагууд	66.8%	62.5%	4.3%
3	Тохируулагч агентлагууд	63.1%	61.2%	2.9%
4	Аймгуудын ЗДТГ	66.1%	61.4%	4.7%
5	Дүүргүүдийн ЗДТГ	63.8%	62.7%	1.1%
6	Парламентын харьяа байгууллагууд	65.7%	64.5%	1.2%
Ерөнхий дундаж		65.2%	63.1%	2.1%

Яам, Хэрэгжүүлэгч агентлаг, болон Аймгийн ЗДТГ нарын үр дүн өнгөрсөн онтой харьцуулахад хамгийн их өсөлт үзүүлсэн байна. Яамдын хувьд Зам тээвэр хөгжлийн яам нийт байгууллагуудаас тэргүүлж (81%), хоёрт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (77%), гуравт Байгаль орчин аялал жуулчлалын яам (76%) эрэмбэлэгдлээ.

Мэдээллийн ил тод байдлыг ихэнх тохиолдолд Шилэн дансны хуулийн хүрээнд харж, хэрэгжүүлж байгаа нь хэрэглэгчдэд хүртээмжгүй байхад нөлөөлж байна. Тиймээс байгууллага тус бүр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр байгууллага тус бүр нээлттэй мэдээллийн хүрээ, хангах үйл явц, үүрэг хариуцлага, хяналтын механизм, нөөц зэргийг тусгасан баримт бичиг, журмыг дотооддоо баталж мөрдүүлэх хэрэгтэй.

Цахим хуудасны дизайн, технологийн шийдлүүд сайжирч байгаа боловч дотор нь байршуулж буй мэдээллийг ашиглахад хялбар байлгах тал дээр сайжруулах шаардлага байсаар байна.

Ерөнхийд нь дүгнэвэл төрийн байгууллагууд мэдээллийг цахим хэлбэрээр байршуулахдаа ямар нэг холбогдох хууль тогтоомжийг хангах үүднээс байршуулж байгаа ба хэрэглэгчийн өнцгөөс тэдэнд мэдээлэл хайх, хүлээн авахад хялбар байх талаас нь бодолцон сайжруулах, энэ чиглэлд холбогдох албан хаагчдыг чадавхжуулах шаардлагатай байна. Тиймээс тайланд зарим сайн байж болох жишээнүүдийг дурдаж оруулсан ба тэдгээрээс өөр хоорондоо суралцаж, сайжруулах боломж бүрдэх юм.



Сайн | >80 | Хангалттай | 65-79 | Сул | 50-64 | Хангалтгүй | 35-49 | Мүү | <35

Цахим ил тод байдлын өөрчлөлт, оноор

# УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨӨС ҮҮДЭЛТЭЙ БАЙГАЛИЙН ГАМШИГТ ӨРТСӨН ИРГЭДИЙН САЙН САЙХАН БАЙДАЛ 2022-2023



Судалгааны тайлангийн холбоос

## ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

IRIM судалгааны хүрээлэн өөрсдийн бие даасан бүтээгдэхүүн болох **"Нийгмийн сайн сайхан байдлын судалгаа"**-г зургаа дахь жилдээ хийж гүйцэтгэлээ. Уг судалгаа нь нийгмийн хөгжил болон нийгмийн сайхан сайхан байдалд нөлөөлж буй хүчин зүйсийн талаарх ойлголтыг

сайжруулахад тусалж, баримт нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргалтыг дэмжихэд хувь нэмрээ оруулах зорилгоор Монголын нийгмийн сайн сайхан байдлыг хэмжихдээ дараах хоёр агуулгыг суурь болгосон.

### Нийгмийн нийцэл



**Хамтын ажиллагаа**

Харилцан бие биедээ тусалдаг, хамтардаг байх.



**Итгэлцэл бий болох**

Нийгмийн гишүүд бие биедээ болон улс төрийн институцудад итгэдэг байх.



**Бие биеэс харилцан хамаарах**

Нийгмийн гишүүдийг нэгтгэж байдаг "адилсал" байх, нийгмийн аль нэг бүлэгт хамаарч буйгаа мэдэрч байх.

### Субъектив сайн сайхан байдал



**Амьдралын утга учрын үнэлгээ**

Аз жаргалтай байдал, эерэг сэтгэл хөдлөлөөс илүү субъектив сайн сайхан байдлыг илэрхийлдэг. Хүмүүсийн амьдралын утга учир болох зорилгыг эрхэн мэдэрч байгаа, сэтгэл зүйн хувьд хар хангалуун байгааг илэрхийлдэг.



**Сэтгэл хөдлөл**

Хувь хүний сайн сайхан байдлыг өдөр тутмын нөхцөл байдал дээр үнэлэхийн тулд хүмүүсийн богино хугацаан дахь мэдрэмж болон сэтгэл санааны байдлын талаар асуудаг.



**Амьдралын сэтгэл ханамж**

Хүний амьдрал эсвэл түүний гадархай үеүдийн талаарх хувийн когнитив үнэлгээ. Хүмүүсийн өөрийнхөө амьдралын талаар эргэцүүлэн бодож, ерөнхийдөө амьдрал нь эерэг үнэ өгж байгааг үнэлүүлдэг.

Судалгааны хүрээнд жил бүр нийгмийн ялгаатай бүлгүүдийг зорилтот түүврээр сонгон авч тухайн бүлгийн нийгмийн сайн сайхан байдлыг шинжлэх ухааны арга, аргачлалаар цуглуулсан дата мэдээлэлд тулгуурлан тайлбарлахыг зорьдог билээ. Уг судалгаа нь өнгөрсөн хугацаанд дараах онцлогуудыг тусган хийгдэж байв. Үүнд:

- 2016-2019 оны хооронд жил бүр нийгэм цаг үеийн ялгаатай мөчлөгүүдэд мэдээллийг цуглуулж, цаг үеэс хамаарч иргэдийн сайн сайхан байдал хэрхэн өөрчлөгдөж буйг харьцуулан судалж байв.
- 2020 онд “Ахмад настнуудын нийгмийн сайн сайхан байдал” сэдэвчилсэн судалгааг гүйцэтгэв.

## ЗОРИЛГО

Судалгааны багийн зүгээс 2022 - 2023 онуудад дэлхийн нийтэд нэн тулгамдсан асуудал болоод буй уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг онцолж, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх Монголчуудын мэдлэг, хандлага, дадал болон гамшиг, эрсдэлд тэсвэрлэж үлдэх байдал нь нийт хүн амын сайн сайхан байдалд хэрхэн нөлөөлж буйг тодруулах зорилготой ажилласан.

## СУДАЛГААНЫ ДИЗАЙН

Сайн сайхан байдал нь “Кантрилын шатлал” (өөрийн үнэлгээний шкал) ашиглан хэмжсэн нийлмэл индекс юм. Энэ нь хүмүүсийг өөрсдийн амьдралыг байж болох хамгийн сайнаас (10 эсвэл 7) хамгийн муу (0) хооронд сайн сайхан байдлаа хэрхэн үнэлж байгааг асуудаг бөгөөд гамшигт өртсөн бүлгийн нийгмийн сайн сайхан байдлыг тодорхойлохдоо 11 сонголт бүхий Кантрилын шкалыг ашиглан, үр дүнг эдгээрийн дунджаар илэрхийлсэн.


Судалгаанд Улаанбаатар хотын бүх дүүрэг, 13 аймаг, 26 сумдаас түүвэрлэсэн 2800 орчим иргэн хамрагдсан бөгөөд үүнээс уур амьсгалаас үүдэлтэй байгалийн гамшигт өртсөн бүлэг болон ерөнхий бүлэгтэй нь харьцуулах замаар сайн сайхан байдлын судалгааны үр дүнг илэрхийлсэн.

## ҮР ДҮН, ДҮГНЭЛТ


Эдгээр судалгаанууд нь итгэлцэл, хамтын ажиллагаа, амьдралын сэтгэл ханамж гэсэн гурван чухал хэмжүүрийн талаарх ихээхэн үнэ цэнтэй үр дүнгүүдийг гаргаж өгдөг.

- Итгэлцлийн тухайд, гамшигт өртсөн бүлгийн дунд итгэлцэл мэдэгдэхүйц өндөр байсан нь хүн хоорондын харилцаа болон олон нийтийн дундах гамшгийн даван туулах чадавхын ач холбогдлыг харуулж байсан юм.
- Гэсэн хэдий ч Засгийн Газар зэрэг байгууллагуудад итгэх итгэл бага байгаа нь байгалийн гамшигт үр дүнтэй хариу арга хэмжээ авах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хүчин чармайлтуудад сорилт болж болзошгүйг харуулж байлаа.

Судалгаанд оролцогчдын нийгмийн бүлгүүдэд итгэх байдлын дундаж утга



Судалгаанд оролцогчдын нийгмийн институцуудад итгэх байдлын дундаж утга





- **Хамтын ажиллагааны хувьд**, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, гамшгийн бэлэн байдлын үйл ажиллагаанд оролцох хандлага эрс нэмэгдэж, байгаль орчны **тулгамдсан асуудлуудыг хамтдаа шийдвэрлэх эрмэлзэл өндөр** байгаа нь харагдаж байлаа.

“Кантрилийн шатлал” аргыг ашиглан амьдралын сэтгэл ханамжийг нь үнэлүүлэхэд, судалгаанд оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин харилцан адилгүй байгаа нь харагдсан бөгөөд энэ нь зарим талаараа гамшигт нэрвэгдсэн туршлагаас хамааран ялгаатай байв.

Эдгээр үр дүн нь байгаль орчинтой холбоотой хүчин зүйлс болон субъектив сайн сайхан

байдал хоёрын хооронд нарийн уялдаа холбоо байгааг онцолсон бөгөөд олон нийтийн дундах гамшгийн даван туулах чадавхыг бий болгохын тулд бүхэл дүр зургаар нь харах холистик аргачлал ашиглах шаардлагатай байгааг харуулж байлаа. Цаашдаа бид гамшигт өртөмтгий бүсүүд дэх гамшгийг даван туулах чадавх бүхий олон нийтийг бий болгохын тулд итгэлцлийг хөхиүлэн дэмжих, олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах, амьдралын ерөнхий сэтгэл ханамжийг сайжруулахад чиглэсэн зорилтот нөлөөллийн ажлууд шаардлагатай байгаа нь харагдлаа. Оролцогч талуудын зүгээс эдгээр чухал хэмжүүрүүдийг харгалзсан арга хэмжээ авч хэрэгжүүлснээр ирээдүйд тулгарах сорилтуудыг илүү итгэлтэйгээр, нэгдсэн байдлаар давж гарахуйц, дасан зохицох чадавх бүхий тэсвэртэй олон нийтийг бий болгож чадна.

### Судалгаанд оролцогчдын хамтын ажиллагааны түвшин

Ямар нэгэн байгууллагад гишүүнчлэлтэй эсэх



Байгалийн гамшгийн үед бүлгүүдэд дэмжлэг үзүүлэх байдал



# ЗАСАГЛАЛ

Манай байгууллага 2008 онд байгуулагдсан цагаасаа эхлэн засаглалын салбарт төвлөрөн ажиллаж ирсэн бөгөөд засаглалын төслүүд IRIM-ийн хэрэгжүүлж буй нийт төслийн 20 гаруй хувийг дангаар эзэлдэг. Одоогийн байдлаар нийт 70 гаруй урт болон богино хугацааны үр нөлөө бүхий засаглалын судалгааны төслүүдийг хэрэгжүүлээд байна. Үүн дундаа бид **өгөгдөлд суурилсан (data-driven) цахим (e-governance and digital transformation) болон нээлттэй, ил тод засаглалыг (open governance initiatives)** бэхжүүлэхэд чиглэсэн судалгааны ажлуудад төвлөрөн, дараах салбар чиглэлээр судалгааны арга зүй, аргачлалаа тогтмол сайжруулан ажиллаж байна.



**Төрийн үйлчилгээний ил тод байдал, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд:** Төрийн үйлчилгээний ил тод байдал, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор бид 2010-2011 онд төрийн байгууллагын цахим ил тод байдлыг үнэлэх арга зүйн анхны хувилбарыг боловсруулж, улмаар 2014 оноос хойш жил бүр төрийн байгууллагын цахим ил тод байдлыг бие даасан байдлаар үнэлж ирсэн. 2019 онд үнэлгээний арга зүйгээ шинэчилж, олон улсад ашиглагдахуйц төрийн байгууллагын **"Цахим ил тод байдлын индекс"**- ийг боловсруулж, Монгол болон Киргизстан Улсуудад амжилттай хэрэгжүүлсэн туршлагатай. Уг индексийг манай хүрээлэн жил тутам нийгмийн хариуцлагын хүрээнд бие даасан байдлаар гүйцэтгэж, олон жилийн давтамжтай харьцуулалт хийхийг зорьж байгаа бөгөөд үр дүнд суурилан төрийн байгууллагуудад чиглэсэн нөлөөллийн ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

Мөн манай хүрээлэн 2008 оноос хойш орон нутгийн төсвийн ил тод байдлын чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн судалгааны ажлуудыг тасралтгүй гүйцэтгэж, 2014 онд **"Шилэн дансны тухай хууль"** батлагдахад нөлөөлж, **"Орон нутгийн хөгжлийн сангийн үнэлгээ"**-г үндэсний хэмжээнд гүйцэтгэх, талуудыг чадавхжуулах ажлуудад сүүлийн 5 жил тасралтгүй оролцож, орон нутгийн засаглалын хөгжилд өөрсдийн хувь нэмрээ оруулсаар байна.

ГИШҮҮНЧЛЭЛ



Засаглалын чиглэлээр бид Төв Азийн бүсийн иргэний нийгмийн байгууллагуудын эрхийг хамгаалах зорилготой **Innovation for Change** (I4C) олон улсын сүлжээнд 2018 оноос гишүүнээр ажиллаж байна. Мөн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP), Азийн сан (TAF), Авлигатай тэмцэх газар зэрэг төр болон олон улсын байгууллагуудтай засаглалын чиглэлээр тогтвортой хамтын ажиллагаатай.

**Төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмж, иргэдийн сэтгэл ханамжийг тодорхойлох чиглэлд:** Төрөөс хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэлийг иргэд, олон нийтээр үнэлүүлэх, цаашлаад төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үр дүн, зөвлөмжийг бодлого боловсруулагчдад санал болгох зорилготой судалгааны ажлуудыг гүйцэтгэх нь засаглалын салбар дахь манай байгууллагын дараагийн гол чиглэл юм.

Энэ хүрээнд бид **төрийн үйлчилгээний талаарх хэрэглэгчийн үнэлгээг** 2012 оноос хойш яам, агентлагуудтай хамтран салбарын түвшинд, 2019 оноос ЗГХЭГ-тай хамтран үндэсний түвшинд хийж гүйцэтгэсэн туршлагатай. Мөн **"Нэг цонхны үйлчилгээ" төслийн суурь, явцын болон эцсийн үнэлгээг (2013-2014)** гүйцэтгэсэн нь төрийн үйлчилгээг иргэдэд нэг цэгээс хүргэх байдлыг нэмэгдүүлэхэд суурь мэдээллийг цуглуулсан чухал ажил болсон.

Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх зорилгынхоо хүрээнд бид Ази Номхон далайн улс орнуудын **'Нийгмийн хариуцлагын төлөөх сүлжээ'** байгууллагын гишүүнээр 2010 оноос хойш ажиллаж байна. Мөн энэ чиглэлийн төсөл, судалгааны ажлуудад Дэлхийн банк (WB), Швейцарын хөгжлийн агентлаг (SDC), Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар зэрэг төр болон олон улсын байгууллагуудтай голлон хамтарч ажиллаж байна.

**Ардчилал, хүний эрх, иргэний оролцооны чиглэлд:** IRIM судалгааны хүрээлэн ардчилал болон иргэний орон зай, иргэний эрхийн чиглэлээр идэвхтэй ажиллаж ирсэн. Энэ чиглэлд хэрэгжүүлсэн онцлох ажлуудаас дурдвал 2018 онд Дэлхийн Нийгмийн Сангийн дэмжлэгтэйгээр **"21-р зууны Ардчилал: Сорилтууд ба**

**цаашдын хандлага"** сэдвийн хүрээнд 14 орны 31 илтгэгч, 100 орчим оролцогчдыг хамруулсан олон улсын бага хурлыг Монголд амжилттай зохион байгуулж байсан. Уг хурлын үр дүнд **"Ардчиллын тэмцэл сорилтын жилүүдэд: Монгол ба Дэлхийн улс орнууд туршлагажиж эхэлсэн нь"** сэдэвт эрдэм шинжилгээний эмхэтгэл ном бүтээгдсэн бөгөөд Англи, Монгол хэлээр олон нийтэд нээлттэй түгээж, олон орны судлаачдын хүртээл болсон. Мөн ардчилал, сонгуулийн тогтолцоо, иргэдийн оролцооны асуудлаар жил бүр олон нийтийн санаа бодлын тандалт судалгаануудыг зохион байгуулж ирсэн нь бодлого боловсруулагч, эрдэмтэн судлаачид, иргэд олон нийтийн дунд танилцуулагдаж, хэлэлцүүлгийн сэдэв болж ирсэн.

2020 оноос Азийн Ардчиллын Судалгааны Сүлжээ (**Asia Democracy Research Network**)-д гишүүнээр ажиллаж, ардчиллын чиглэлээрх судалгааны үр дүнгээ олон улсад хуваалцах, хамтын ажиллагаа бий болгох чиглэлээр идэвхтэй ажиллаж байна. Мөн энэ чиглэлийн судалгааны ажлуудаар Америкт төвтэй Ашгийн Төлөө Бус Хуулийн Олон Улсын Төв (ICNL), АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID), Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн (IRI) зэрэг олон улсын байгууллагуудтай голлон хамтран ажиллаж байна.

Засаглалын салбарт нийгмийн олон талт бүлгийн оролцоо, төлөөллийг хангах асуудал чухалд тавигддаг тул бид засаглалын чиглэлээр хэрэгжүүлж буй бүхий л судалгаа, төслүүддээ жендер, хөгжлийн бэрхшээл, нийгмийн эмзэг бүлгийн төлөөллийг тэгш хамруулах **GEDSI approach (Gender Equality, Disability and Social Inclusion)**-ыг баримтлан ажилладаг. 2024 онд засаглалын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах чухал арга зам болох улс төрийн сонгууль дэлхийн 60 гаруй улсад өрнөж, дэлхийн хүн амын тэн хагас нь сонгуульд оролцох онцлог үе тохиож байна. Үүнтэй холбоотойгоор сонгох, сонгогдох эрхээ нийгмийн бүх бүлгүүд адил тэгш эдлэхэд хувь нэмэр оруулахын тулд IRIM судалгааны хүрээлэн засаглалын чиглэлээр хийгдэж буй судалгааны төслүүдийн бүх үе шатанд дуу хоолой нь орхигдох эрсдэлтэй бүлгийн төлөөллийг тэгш хамруулахыг зорин ажиллаж байна.

## МОНГОЛ УЛСАД ТАЙВАН ЗАМААР ЖАГСАХ, ЦУГЛАХ ЭРХИЙГ ДЭМЖИХ НЬ

2023.12 - 2024.04

ICNL  
INTERNATIONAL CENTER  
FOR NOT-FOR-PROFIT LAW



### ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын иргэн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. *Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль 1994 онд анх батлагдсанаас хойш таван удаа шинэчлэгдсэн ч жагсаал, цуглааны үеэр хүний эрх зөрчигдөх, гэмт хэрэг, зөрчлүүд гарсаар байна.*

Монгол Улсад 2020-2022 оны хооронд 710 жагсаал, цуглаан зохион байгуулагдсан ба ХЭҮК-ийн Улаанбаатар хотод зохион байгуулагдсан томоохон жагсаал, цуглаанд хийсэн ажиглалтад үндэслэн “Монгол Улсад хүний тайван жагсах, хуран чуулах эрх чөлөөгөө эдлэх баталгаа хэврэг, энэ орон зай хумигдах эрсдэлтэй байна” гэжээ. Тиймээс Монгол улсад тайван замаар жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, *Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд ХЭҮК, Хууль зүйн үндэсний хүрээлэн, судлаачид дүгнэлт хийсэн байна. Тухайлбал, (Мөнхсайхан, 2017) цуглаан хийх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг ноцтой зөрчсөн гурван тохиолдлыг онцлон тэмдэглэжээ. Үүнд:*

- аяндаа үүссэн цуглааныг хүлээн зөвшөөрдөггүй;
- жагсаал цуглаан жагсаал цуглаан хийх мэдэгдлийг бүртгүүлэх гэсэн нэртэй боловч

эрх бүхий албан тушаалтнаас зөвшөөрөл авах тогтолцоог хуульчилсан;

- бүртгэлгүй цуглааныг албадан тараахдаа хуульчилсан журмыг цагдаа нар дагаж мөрдөхгүй байх.

Иймд иргэдийг жагсаал, цуглаанд оролцох бэлтгэлийн талаар нарийн мэдээлэлтэй болгох нь нэн чухал. Үүнд ийм үйл явдлын үеэр болон дараа нь тэдний эрх чөлөө, аюулгүй байдлаа хэрхэн хамгаалах, асуудал тулгарвал шийдвэрлэх зэрэг орно. Энэ нь иргэдийн тайван замаар цуглах эрхийг хангахад амин чухал юм.

### ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Иргэд тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөгөө хамгаалах талаар мэдлэг, мэдээлэл дутмаг байгаагаас болж жагсаал, цуглаан хийх эрх зөрчигдөж байна. Иргэдийн жагсаал, цуглаан хийх эрхийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор энэхүү ажлыг эхлүүлсэн билээ. Үүний зэрэгцээ тайван жагсаал цуглаан хийх эрх зүйн орчныг сайжруулахад хувь нэмрээ оруулж, эдгээр эрхийг хамгаалахад хуульчдын чадавхыг нэмэгдүүлэхийг зорьж байна.

Үүний хүрээнд IRIM судалгааны хүрээлэнгээс Хууль зүйн мэдээлэл, судалгааны хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран ICNL сангийн дэмжлэгтэйгээр “Монгол Улсад тайван замаар жагсах, цуглах эрхийг бэхжүүлэх нь” төслийг 2023 оны 12 сараас 2024 оны 4 сар хүртэлх хугацаанд хэрэгжүүлж байна.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН

Төсөл нь дараах хоёр бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

### Бүрэлдэхүүн 1: Тайван замаар цуглах эрхийн хүрээнд иргэдийг чадавхжуулах

- Өмнө нь болсон 10 орчим жагсаал цуглаан дээр **кэйс судалгаа** хийх
- Кэйс судалгаанаас гарсан сургамж дээр үндэслэж иргэдэд зориулсан **гарын авлага** боловсруулан түгээх

### Бүрэлдэхүүн 2: Тайван замаар цуглах эрхийг хамгаалах хуульчдыг чадавхжуулах

- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан **"Тайван замаар жагсах, цуглах эрхийг дэмжих хуульчдад зориулсан гарын авлагыг"** орчуулах
- 15 хуульчдад сургалт зохион байгуулах

## ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

### Бүрэлдэхүүн 1: Тайван замаар цуглах эрхийн хүрээнд иргэдийг чадавхжуулах

Судалгааны багийн зүгээс Монгол Улсын хэмжээнд зохион байгуулагдсан 10 жагсаал, цуглааныг сонгон кэйс судалгааг хийж гүйцэтгэсэн. Жагсаал цуглааныг сонгохдоо 1) хугацаа 2) оролцогчдын тоо 3) байршил зэрэг ерөнхий шалгуур үзүүлэлтийг харгалзан үзсэн.

Төслийн багийн зүгээс кэйс судалгааны үр дүнд бий болсон туршлага, сургамждаа үндэслэн жагсаал, цуглаан зохион байгуулах явцад тулгарч болох эрсдэл болон анхаарах шаардлагатай зөвлөмжүүдийг агуулсан гарын авлагыг олон нийтэд зориулан гаргасан. Гарын авлагад багтсан зөвлөмжүүд нь

- Жагсаал, цуглаан болохоос өмнө: Бэлтгэл хангах шат,
- Жагсаал цуглааны үеэр,
- Жагсаал, цуглааны дараа гэсэн үндсэн 3 бүлэгт хуваагдан боловсруулагдсан.

Гарын авлагыг цахим орчинд болон ИНБ, Хуульчдын сүлжээгээр түгээв. Ингэхдээ гарын авлагыг постер, богино хэмжээний бичлэг болон эх хувилбар хэлбэрээр нийтэлсэн.

### Бүрэлдэхүүн 2: Тайван замаар цуглах эрхийг хамгаалах хуульчдыг чадавхжуулах

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан **"Тайван замаар жагсах, цуглах эрхийг дэмжих хуульчдад зориулсан гарын авлага"**-ийг монгол хэл рүү орчуулав. Энэхүү гарын авлага тайван замаар жагсах, цуглах эрхийг хангахад хуульчдын гүйцэтгэх үүргийн талаарх үндсэн зарчмуудын багцыг, мөн хуульчдад зориулсан практик зөвлөмжийг агуулсан болно.

Тайван замаар жагсах, цуглах эрхийг дэмжих, хамгаалах хуульчдад зориулсан сургалтыг зохион байгуулах: Төслийн баг орчуулсан гарын авлагыг ашиглан 15 хуульчдын дунд нэг өдрийн сургалтыг зохион байгууллаа.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль болон шийдвэр гаргагчдад зориулсан зөвлөмж боловсруулах: Сургалтын төгсгөлд хуульчид **"Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль"**-ийг боловсронгуй болгох бодитой саналуудыг гаргахыг зорьж ажиллаа. Эдгээр саналууд нь оролцогчдын туршлага, ойлголтод тулгуурлан, бэрхшээлийг шийдвэрлэх, жагсаал цуглааны үеэр иргэдийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулахад чиглэгдэв.

## Кейс судалгааны жагсаалт

#	Жагсаал, цуглааны нэрс	Шалгуур		
		Хугацаа	Жагсагчдын оролцооны тоон байдал	Байршил
1	Эмч, эмнэлгийн ажилтнуудын цалингаа нэмүүлэхийг шаардсан ажил хаялт, суулт	2021	Их	Улаанбаатар
2	'Nodouble standard, Nonaadam, Nowar' сэдэвт жагсаал, цуглаан	2021-2022	Их	Улаанбаатар
3	Ерөнхий сайд огцорсон цуглаан	2021	Их	Улаанбаатар
4	'Монголоо аваръя' жагсаал	2022	Бага	Улаанбаатар
5	Долоодугаар сарын нэгний түйвээн	2008	Их	Улаанбаатар
6	Орон нутагт болсон жагсаал, цуглаан	2022	Их	Орон нутаг
7	'Гал үндэстэн холбоо', 'Монголын гол нууруудын нэгдсэн хөдөлгөөн' -ийнхний жагсаал	2012-2013	Дунд	Улаанбаатар
8	'Эвлэлдэн нэгдэх - хөдөлмөрлөх эрхээ эдэлье' жагсаал	2016	Их	Улаанбаатар
9	Япон дахь Монголчуудын Шогукан хэвлэлийн компанийн гаднах жагсаал	2018	Бага	Гадаад
10	'Монголдоо сайхан амьдаръя, ажлаа хий' жагсаал	2022	Их	Улаанбаатар

## ОЛОН НИЙТИЙН САНАЛ БОДЛЫН СУДАЛГАА-2024

2024.02 - 2024.05



### ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

“Олон нийтийн санал бодлын судалгаа-2024” нь ардчилал, хүний эрх, улс төр, эдийн засаг, нийгмийн нөхцөл байдлын талаар ард иргэдийн санал бодлыг тандах зорилготой хийгдэж буй цуврал судалгаануудын нэг юм. Захиалагч байгууллага болох Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн (БНОУХ) нь ардчилал, эрх чөлөө, олон нийтэд тулгуурласан хөгжил болон эрх зүйт ёсыг дэлхий дахинаа хөгжүүлэхийн төлөө ажилладаг байгууллага бөгөөд дэлхийн олон оронд энэ сэдвээр судалгаа, нөлөөллийн ажлуудыг гүйцэтгэдэг. Тус байгууллагаас өмнөх 2020, 2021, 2022 онуудад зохион байгуулсан олон нийтийн санаа бодлын судалгаанд мөн IRIM судалгааны хүрээлэн хамтран ажилласан юм.

### ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Уг төслийн зорилго нь (i) Засгийн газрын талаарх иргэдийн сэтгэл ханамж, (ii) сонгогдсон албан тушаалтнуудын хариуцлагатай байдал, (iii) эмэгтэйчүүд, залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоо, (iv) Засгийн газрын ерөнхий гүйцэтгэлийн талаарх олон нийтийн санал бодлыг судлах юм. Үүний хүрээнд төслийн баг нь дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

- Захиалагч талаас санал болгосон арга зүй, асуумж хэрэглэгдэхүүнийг туршиж, сайжруулах үйл явцыг хариуцан зохион байгуулах
- Зорилтот орон нутгуудад мэдээлэл цуглуулах төлөвлөгөө гарган, утсан судалгааны дата баазыг дотоод мэдээллийн сангаас бүрдүүлж бэлтгэх
- Талбарын мэдээлэл цуглуулалтын ажлыг дуудлагын төвийг ашиглан Монгол Улсын 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргээс 2000 өрхийг түүвэрлэн утсан судалгаагаар мэдээлэл цуглуулалтын ажлыг зохион байгуулах
- Цугларсан мэдээллийг зориулалтын программд оруулж, чанарын шаардлага хангасан дата сан үүсгэн захиалагчид хүлээлгэн өгөх
- Мэдээлэлд шинжилгээ хийж, түүний үр дүнд суурилан Аналитик тайлан бэлтгэх

Уг судалгаа нь нэг цаг хугацаанд өргөн хүрээг хамрах буюу “хөндлөн үргэлжлэх” (cross-section) дизайнтай байна. Үндэсний түвшний судалгаагаар засгийн газрын бодлого, үйл ажиллагаа, улс төрийн өнөөгийн нөхцөл байдлыг олон нийтийн санал бодлоор тодорхойлох зорилготой судалгаа юм.

## ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

Энэхүү төсөл нь 2024 оны 5 сар хүртэл үндэсний түвшинд үргэлжлэх ба одоогоор мэдээлэл цуглуулах шатандаа хэрэгжиж байна. Түүнчлэн IRIM судалгааны хүрээлэн нь зөвхөн мэдээлэл цуглуулах шатанд зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд үр дүн, тайлан боловсруулах шатанд оролцохгүй болно.

Судалгааны үр дүнгийн танилцуулгууд:

**ЗАЛУУЧУУДЫН САНАЛ  
БОДЛЫН СУДАЛГАА**

2020 оны 5-р сарын 14-нөөс 6-р сарын 15

 CENTER FOR  
INSIGHTS IN  
SURVEY  
RESEARCH  
A PROJECT OF THE INTERNATIONAL REPUBLICAN INSTITUTE



**ОЛОН НИЙТИЙН САНАЛ  
БОДЛЫН СУДАЛГАА**

2021 оны 3-р сарын 11-нээс 4-р сарын 20

 CENTER FOR  
INSIGHTS IN  
SURVEY  
RESEARCH  
A PROJECT OF THE INTERNATIONAL REPUBLICAN INSTITUTE



**ОЛОН НИЙТИЙН САНАЛ  
БОДЛЫН СУДАЛГАА**

2022 оны 03-р сараас 04-р сар

 CENTER FOR  
INSIGHTS IN  
SURVEY  
RESEARCH  
A PROJECT OF THE INTERNATIONAL REPUBLICAN INSTITUTE



# ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ БА ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Тогтвортой хөгжлийн 8 дахь зорилго болох *'Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох'*-д судалгаа, үнэлгээний ажлаараа дамжуулан өөрсдийн хувь нэмрээ оруулах үүднээс IRIM судалгааны хүрээлэн эдийн засаг ба хөдөлмөр эрхлэлтийн чиглэлд төвлөрөн ажиллаж байна. Уг салбар судлагдахуун нь манай байгууллагын туршлага бүхий салбар бөгөөд бидний нийт хэрэгжүүлсэн төслүүдийн 50 орчим хувь нь аль нэг хэлбэрээр уг салбарт хамаардаг. Үүн дундаа **жижиг дунд бизнес эрхлэгчид, хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага, динамикийг судлах, хөдөлмөрийн бүтээмж, зохистой хөдөлмөр эрхлэлтийн** судалгааны төслүүд зонхилдог ба сүүлийн жилүүдэд хөдөлмөрийн эдийн засагт томоохон чиглэлүүдийн нэг болон гарч ирж байгаа **Асрахуйн эдийн засаг (Care economy)**-ийн чиглэлээр бид судалгаа, зөвлөх үйлчилгээний чадавхаа бэхжүүлэхэд анхааран ажиллаж байна.

Хүртээмжтэй эдийн засаг ба зохистой хөдөлмөрийн чиглэлээр голлон төвлөрч буй судалгааны дэд чиглэлүүдийг танилцуулбал:



## ГИШҮҮНЧЛЭЛ



IRIM Төв Азийн Бүс Нутгийн Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Институт (CAREC) сүлжээнд 2022 онд нэгдэн орсон ба уг институт нь Төв Азийн орнууд болон хөгжлийн түншүүдийн хамтын ажиллагаагаар дамжуулан хөгжлийг дэмжин эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, ядуурлыг бууруулах чиглэлд үйл ажиллагаа явуулдаг. Уг институтээс жил тутам зохион байгуулдаг Төв Азийн Тинк танкуудын сүлжээний форумд IRIM судалгааны хүрээлэн 2022 оноос хойш жил тутам оролцож, бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны талаарх цаг үеийн мэдлэгээ тасралтгүй нэмэгдүүлж, судалгаа, шинжилгээний байгууллагын хувиар Монголын контекст туршлагыг мөн хуваалцаж, идэвхтэй хамтран ажиллаж байна



**Хөдөлмөрийн зах зээл:** Салбаруудын хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хууль эрх зүйн орчин, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, тогтвортой байдлын судалгаанууд нь хөдөлмөрийн зах зээл дундаа бидний чадавх бүхий үндсэн салбар сэдэв юм. Энэ хүрээнд дээд, техникийн болон мэргэжлийн боловсролын сургууль төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлыг мөшгөх, тэдний ур чадвар ажил олгогчдын шаардлага, хэрэгцээнд нийцэж байгаа эсэхийг тодорхойлоход чиглэсэн судалгаа, зөвлөх үйлчилгээний ажлуудыг голлон гүйцэтгэж байна.

**Эдийн засгийн өсөлт:** Эдийн засгийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүд болох уул уурхай, хөдөө аж ахуйн салбарын судалгааг гүйцэтгэхийн зэрэгцээ бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчид, малчин, тариаланч өрхүүдийн эдийн засагт оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн процесс, бүтээгдэхүүн, үйлчилгээнд нэмүү өртөг шингээх боломжийг тодорхойлох зорилготой судалгааны ажлуудыг голлон гүйцэтгэж байна. Тухайлбал, 2023 онд бид "Жижиг дунд бизнесийн өрсөлдөх чадварын судалгаа"-г Олон Улсын Худалдааны Төв (ОУХТ)-ийн ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матрицан аргачлалд тулгуурлан үндэсний хэмжээнд зохион байгуулсан. Уг судалгаа нь ЖДБ-ийн өрсөлдөх чадвар, түүний орчин нөхцөл байдлыг цогцоор нь тодорхойлж, цаашдын хэрэгцээ шаардлагыг үнэн зөв оновчлох боломжийг бүрдүүлсэн ажил болсон бөгөөд цаашид бизнесийн орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн бодлогын шийдлийг боловсруулахад ашиглагдах чухал нотолгоо болох юм.

**Нийгмийн хамгаалал:** Нийгмийн хамгааллын хөтөлбөрүүд нь хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, хүмүүсийн зохистой ажлын байр олох чадавхыг нэмэгдүүлснээр тогтвортой эдийн засгийн өсөлтөд шууд хувь нэмрээ оруулж байдаг. Бид нийгмийн хамгааллын хөтөлбөр, төслүүдийн үнэлгээний ажлуудыг гүйцэтгэдгээс гадна зорилтот бүлгийн

өрхүүдийг чадавхжуулах замаар өрхийн амьжиргааг дээшлүүлэх, жижиг бизнесүүдийг дэмжих замаар зохистой ажлын байр бий болгоход чиглэсэн судалгаа зөвлөх үйлчилгээний ажлуудыг сүүлийн жилүүдэд идэвхтэй гүйцэтгэж байна. Тухайлбал, бид 2023 онд Зорилтот бүлгийн өрхүүдийг төгсөлтийн аргачлалаар бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх зах зээлийн судалгааг гүйцэтгэж, бизнес моделийн багц боловсруулах зөвлөх үйлчилгээг амжилттай үзүүлсэн. Энэхүү судалгаа болон бизнес моделиудад тулгуурлан нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн нийт 1520 өрх АХБ-ны "Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2"-ын санхүүжилтээр өөрт тохирох бизнесүүдээ хэрэгжүүлэхэд чиглэсэн тоног төхөөрөмжийн дэмжлэгийг хүртэн, амьжиргаагаа дээшлүүлэх боломжоор хангагдсан.

**Албадан хөдөлмөр ба хүүхдийн хөдөлмөр:** Зохистой хөдөлмөр эрхлэлтийг бий болгоход тулгарч буй хамгийн том сорилтуудын нэг бол албадан хөдөлмөрийн асуудал бөгөөд энэ нь хүний эрхийн ноцтой зөрчил төдийгүй, хөдөлмөрийн зах зээлийг гажуудуулж, цалинг зохиомлоор бууруулж, хүний нөөцийн капитал, ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг бууруулж, эдийн засгийн өсөлтөд ихээхэн хохирол учруулж байдаг. Монголд ялангуяа уул уурхай, хүнд олборлох үйлдвэрлэл, тээвэр, барилга, үйлчилгээний салбар дах албан бус секторуудад ажиллаж буй иргэдийн дунд албадан хөдөлмөрт өртөх эрсдэл өндөр байдаг. Бид албадан хөдөлмөрийн асуудлыг хүний наймааны нэг хэлбэр болохын хувьд өргөн хүрээнд авч үзэж судалж байсан туршлагатай бөгөөд 2020 онд "Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх Монгол Улсын хүчин чармайлтыг бэхжүүлэх нь төслийн суурь судалгаа", 2021 онд "Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь" төслийн суурь судалгаа, 2022 онд Хүн худалдаалахтай тэмцэх төлөв байдлын тайланг боловсруулах ажлуудыг гүйцэтгэж байсан.

# ТОЙРОГ ЭДИЙН ЗАСАГ БА НОГООН БИЗНЕСИЙН ЧИГЛЭЛД БИЧИЛ, ЖИЖИГ, ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

2022.11 - 2025.05



## ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Дэлхий нийтээр байгалийн баялгийг үр ашигтай, хаягдал багатайгаар эдийн засгийн эргэлтэд оруулахыг чухалчилж анхнаас нь “дахин хэрэглэгдэхүйц” бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, улмаар хэмнэлттэй, үр дүнтэй, ашигтай байх нөхцөлийг бүрдүүлэх эдийн засгийн шинэ загвар руу зорьж байна. Байгаль орчны асуудал хурцаар тавигдах болсон энэ цаг үед бизнесүүд хариуцлагатай бизнесийг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

Гэвч багагүй хугацаанд үргэлжилсэн КОВИД-19 цар тахлын үр нөлөө нь хувь хүн, бизнес, улс орон гэх мэт бүхий л түвшинд, бүхий л салбарт сөргөөр нөлөөлсөн. Азийн Хөгжлийн Банк нь КОВИД-19 цар тахлын дараах жендерийн оролцоотой ногоон бизнесийг дэмжих чиглэлд БНХАУ болон Монгол Улсад бүс нутгийн мэдлэг, техник туслалцааны төслийг санхүүжүүлж байна. Монгол Улсад хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээг IRIM судалгааны хүрээлэн нь Монголын Тогтвортой Санхүүгийн холбоо, Хөгжлийн Шийдэл ТББ болон Германы Аделпи байгууллагуудтай хамтран 2022 оны 11-р сар - 2025 оны 05-р сар хүртэл 3.5 жилийн хугацаанд Улаанбаатар, Хөвсгөл, Архангай аймгуудад хэрэгжүүлж байна.

## ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Зөвлөх үйлчилгээ нь бичил, жижиг, дунд бизнес (БЖДБЭ)-ийн тойрог эдийн засаг, ногоон технологийн талаарх мэдлэг, чадавхыг бэхжүүлэх замаар жендерийн тэгш байдлыг дэмжих үндсэн зорилготой. Тус зөвлөх үйлчилгээ нь эмэгтэй эзэнтэй болон эмэгтэй удирдлагатай БЖДБЭ-ийг КОВИД-19-ийн дараах хямралаас бизнесээ сэргээж, тогтвортой ногоон сэргэлтийг хийхэд нь туслах юм.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН

Зөвлөх үйлчилгээний төслийн хамрах хүрээ нь аялал жуулчлалын салбар дахь хоол, хүнс, сав баглаа боодлын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй эмэгтэй бизнес эрхлэгчдийг хамруулж, тойрог эдийн засаг болон ногоон бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.




Тус зорилгыг хангахын тулд 3 бүрэлдэхүүн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2023 онд хийж, хэрэгжүүлсэн гол ажлуудыг дор хураангуйлан оруулав. Үүнд:

**1 Цогц үнэлгээ:** ТЭЗ-ийг дэмжсэн бодлогын орчин, хууль эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийн зорилтот салбарын эмэгтэй бизнес эрхлэгчдээс судалгаа авч ТЭЗ-ийн туршлагыг нэвтрүүлэх хэрэгцээ, бэлэн байдал, боломж, хүндрэл бэрхшээл, талуудын оролцоо хамтын ажиллагааны талаар цогц үнэлгээ хийж, тайлан боловсруулав. Судалгааны товч үр дүнгээс дурдвал:



**ТЭЗ-ийн талаарх мэдлэг, ойлголт**



Тэдний ихэнх нь ТЭЗ-ийн талаар хязгаарлагдмал ойлголттой ба үүн дотроос хог хаягдлын менежментэд

түлхүү анхаарал хандуулдаг аж. Бизнес эрхлэгчид ТЭЗ-ийг бизнесийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх сонирхол өндөр байгаа нь судалгааны дүнгээр харагдсан хэдий ч энэ талаарх ойлголт, мэдлэг дутмагаас хаанаас, хэрхэн эхлэхээ мэдэхгүй байна. Мөн үүнд санхүүгийн нөөц, урсгал зардал ихээр шаарддаг гэсэн түгээмэл ойлголт нь тодорхой алхам хийхэд саад болж байна.

**2 Чадавх бэхжүүлэх хөтөлбөр:** Хэрэгцээ тодорхойлох судалгааны үр дүнд үндэслэн аялал жуулчлалын салбарт хоол хүнс, сав баглаа боодлын чиглэлд бизнес эрхэлж буй бизнес эрхлэгчдийн тойрог эдийн засгийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлж, чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэв.

Төслийн зорилтот байршлууд болох УБ болон Хөвсгөл, Архангай аймгуудад 7 удаагийн биечилсэн, 2 удаагийн цахим сургалтууд зохион байгууллаа. Сургалтад давхардсан тоогоор 1300 бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч хамрагдав. Сургалтад хамрагдсан бизнес эрхлэгч нарт 6 удаагийн менторын үйлчилгээ үзүүлэв.

Энэхүү жилийн тайланг боловсруулж байх үед Аялал жуулчлалын салбарт жишиг болохуйц тойрог эдийн засгийн концепцыг бизнесийн үйл ажиллагаанд амжилттай хэрэгжүүлж буй шилдэг 15 бизнес эрхлэгчийг шалгаруулж тус бүр 10,000\$ хүртэлх грантын дэмжлэг ажлын олгох сонгон шалгаруулалт хийгдэж байна.

**3 Бодлогын хэлэлцүүлэг:** Дээрх үнэлгээ, чадавх бэхжүүлэх хөтөлбөрийн үр дүнд суурилан үндэсний болон олон улсын түвшинд бий болсон үр дүнгийн талаарх мэдээлэл, туршлага солилцож, бодлогын хэлэлцүүлгийг 2024 оны 5-р сараас 10-р сарын хооронд зохион байгуулахаар бэлтгэл ажлаа хангаж байна.



## ЖИЖИГ, ДУНД БИЗНЕСИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГАА

2023.06 - 2023.11



### ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Жижиг, дунд бизнес (ЖДБ) нь хөгжиж буй орнуудын эдийн засгийн хөгжилд онцгой үүргийг гүйцэтгэдэг. ЖДБ-ийн салбарыг хөгжүүлэх нь ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад онцгой хувь нэмэр оруулдаг тул олон орон ЖДБ-ийн хөгжлийг тэргүүлэх чиглэлээ болгосон байдаг. Монгол Улсын хувьд 2021 оны байдлаар үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн 66.1% нь жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид байна. Тэд ДНБ-ий 5.5%-ийг бүрдүүлж, нийт барааны экспортын 2.4%, импортын 9.7%-ийг гүйцэтгэжээ. ЖДБ-ийн гадаад худалдааны оролцоо жилээс жилд буурах хандлагатай байгааг ҮСХ тэмдэглэсэн байна (ҮСХ, 2021).

ЖДБ-ийн өрсөлдөх чадвар ямар хэмжээнд байгааг компанийн хувьд тодорхойлохоос гадна ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг дэмжих бизнесийн болон макро орчин хэрхэн бүрдсэнийг нарийвчлан тогтоох зайлшгүй шаардлага байна. Ингэснээр ЖДБ-ийн өрсөлдөх чадвар, түүний орчны нөхцөл байдлыг цогцоор нь тодорхойлж, цаашдын хэрэгцээ шаардлагыг үнэн зөв оновчлох боломж бүрдэнэ.

### ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Энэхүү судалгаа нь Монгол Улсад албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж буй жижиг дунд бизнесийн (ЖДБ) өрсөлдөх чадварыг Олон Улсын Худалдааны Төв (ОУХТ)-ийн ЖДБ-ийн өрсөлдөх чадварын аргачлалын дагуу тооцож, үр дүнг тодорхойлох зорилготой байв.

### ТӨСЛИЙН ДИЗАЙН

Уг судалгаанд ОУХТ-ийн ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матрицын үнэлгээ ашигласан бөгөөд харгалзах индикаторуудыг МУ-ын ЖДБ-ийн нөхцөлд нийцүүлэн шинэчилсэн.

ОУХТ-ийн ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матриц нь ААН-ийн өрсөлдөх чадварыг гурван тулгуур хүчин зүйл болох өрсөлдөх чадвар, холбогдох чадвар, өөрчлөгдөх чадварын хувьд тодорхойлж, эдгээрт эдийн засгийн микро, месо, макро орчин хэрхэн оролцож буйг авч үздэг хэрэгсэл юм.

Түүврийн хувьд Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймагт үйл ажиллагаа явуулж байгаа албан бүртгэлтэй, идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 703 ЖДБ-ийг судалгаанд хамруулсан. Энэ төслийг 2023 оны 6 дугаар сараас 11-р сар хүртэл нийт таван сарын хугацаанд хийж гүйцэтгэсэн болно.

### ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матриц



### ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

Компанийн чадавхын хувьд ерөнхий индекс 48.7, өрсөлдөх чадварын дундаж оноо 49.7, холбогдох чадварынх 42.9 оноо, өөрчлөгдөх чадварынх 53.3 оноо байна. Эдгээрээс холбогдох чадварын багана харьцуулах түвшнөөс доогуур үнэлэгдсэн бөгөөд өрсөлдөх ба өөрчлөгдөх чадварын баганаас 7-10 орчим оноогоор доогуур үнэлэгджээ. Ялангуяа бичил бизнесийн хувьд холбогдох чадвар дутмаг байна. Иймд компанийн түвшинд холбогдох чадварыг сайжруулахад анхаарах шаардлага байна.

Бизнесийн экосистемийн хувьд ерөнхий индекс 52.2, өрсөлдөх чадварын дундаж оноо 56.6, холбогдох чадварынх 42.9 оноо, өөрчлөгдөх чадварынх 57.0 оноо байна. Өрсөлдөх ба өөрчлөгдөх чадварын дундаж оноо харьцуулах түвшнөөс дээгүүр, харин холбогдох чадварынх харьцуулах түвшнөөс доогуур үнэлэгджээ. Иймд бизнесийн экосистемийн түвшинд мөн л холбогдох чадварыг сайжруулахад анхаарах шаардлага байна.

Макро орчны хувьд ерөнхий индекс 57.9, өрсөлдөх чадварын дундаж оноо 39.2, холбогдох чадварынх 57.1 оноо, өөрчлөгдөх чадварынх 77.4 гарчээ. Өрсөлдөх чадварын баганын үнэлгээ харьцуулах түвшнөөс доогуур, харин өөрчлөгдөх чадварынх хүчтэй түвшинд үнэлэгдсэн байна. Эдийн засгийн гурван түвшинд өөрчлөгдөх чадварын багана нөгөө хоёр баганаасаа өндрөөр үнэлэгдсэн байна.

Бараа, үйлчилгээ, үйлдвэрлэлийн хүчин зүйл, санхүүгийн зах зээлүүд үр ашигтай ажиллах суурь нөхцөлийг бүрдүүлэхэд макро орчин (national environment) нэн чухал. Тодруулбал, аливаа улсын засгийн газраас эдийн засаг, бизнесийн орчны тухайд хэрэгжүүлж байгаа бодлого аль ч салбарт бизнес эрхлэхэд амар хялбар, цаашилбал, бүх түвшинд (микро, мисо, макро) институтийн сайн орчныг бүрдүүлэхэд зайлшгүй чиглэж байх ёстой билээ.

### ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матрицын хураангуй

Дундаж оноо [0-100]		Индекс	Өрсөлдөх	Холбогдох	Өөрчлөгдөх
Компанийн чадавх	Нийт	48.7	49.7	42.9	53.3
	Бичил	44.1	46.3	38.4	47.5
	Жижиг	52.1	52.6	47.0	56.8
	Дунд	58.3	56.8	51.7	66.5
Бизнесийн экосистем		52.2	56.6	42.9	57.0
Макро орчин		57.9	39.2	57.1	77.4
Харьцуулах түвшин: 44.2					
Сул түвшин: ≤26.5 оноо			Хүчтэй түвшин: ≥70.7 оноо		

## ТӨГСӨЛТИЙН АРГАЧЛАЛААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУРШИЛТЫН ХӨТӨЛБӨР

2022.12 - 2023.05



Хөдөлмөр, нийгмийн  
хамгааллын яам



### ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсад 2020 оны байдлаар 903.4 мянган ядуу хүн ам амьдарч байгаа бөгөөд 14% орчим нь ядуурлын шугамаас дөнгөж дээгүүр байгаа юм. Ийнхүү зорилтот бүлгийн хүн амын нийгмийн халамжийн дэмжлэгийг сайжруулах зорилгоор Азийн Хөгжлийн Банк (АХБ), Монгол Улсын Засгийн Газар (МУЗГ)-аас “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын хоёр дахь төсөл”-ийг хэрэгжүүлсэн. Уг төслийн бүрэлдэхүүн хэсэг болох “Төгсөлтийн аргачлалаар хэрэгжүүлэх туршилтын хөтөлбөр”-ийн зах зээлийн нарийвчилсан судалгааг IRIM судалгааны хүрээлэн 2022 оны 12 дугаар сараас 2023 оны 5 дугаар сарын хооронд хийж гүйцэтгэлээ.

### ЗОРИЛГО, ЗОРИЛТ


Хөтөлбөрт нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргүүдийн 1520 өрх, иргэнийг санамсаргүй түүврийн аргаар сонгон хамруулж, тухайн иргэдийн нийгмийн идэвх оролцоог сайжруулах, ур чадварыг нээн илрүүлж хөгжүүлэх, өрхөд тохирох бизнесийг санал болгох зэрэг олон нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай бүтээгдэхүүнүүдийг боловсруулах нь уг бүрэлдэхүүн хэсгийн зорилго байв.

### ТӨСЛИЙН ДИЗАЙН

Зөвлөх үйлчилгээний хүрээнд “Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөр”-ийн зах зээлийн үнэлгээний дизайны дагуу доорх бүтээгдэхүүнүүдийг боловсруулав. Үүнд:


1. Зах зээлийн ерөнхий нөхцөл байдлын үнэлгээ хийж, тогтвортой амьжиргааны урт жагсаалт гарган, жижиг бизнесийг үнэлэх үнэлгээний аргачлалаар зорилтот бүлгийн иргэдийн чадамжийг үнэлсэн.
2. Дээрх урт жагсаалтаас гарсан тогтвортой амьжиргааны хувилбаруудын зах зээлийн багтаамжийн цар хүрээг тодорхойлох зах зээлийн эрэлтийн судалгааг хийж гүйцэтгэв.
3. Үүний дараагаар дээрх хоёр шатанд хийгдсэн судалгааны үр дүнд үндэслэн зорилтот дүүргүүдэд богино жагсаалт бүхий нийт 24 тогтвортой амьжиргааны багц боловсруулсан. Эдгээр багцыг боловсруулахдаа үйл ажиллагаа бүрд нэмүү өртгийн сүлжээг тодорхойлж, санхүүгийн шинжилгээг хийсэн.
4. Хөтөлбөрт оролцогчдын хувиараа хөдөлмөр эрхлэхэд бэлэн байдлын үнэлгээний (профайлинг) хэрэглэгдэхүүнийг боловсруулсан болно.

Зах зээлийн судалгааны зарим үр дүнгээс зорилтот гурван дүүргийн зах зээлийн багтаамжийг тодорхойлоход нийт ААНБ-ын олонх нь худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бол цөөнх нь үйлдвэрлэлийн чиглэлээр, багахан хэсэг нь үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна.



- СХД-ийн ААНБ-ын тоонд худалдаа эрхлэгчдийн эзлэх хувь маш өндөр.
- БЗД-ийн ААНБ-ын тоонд үйлчилгээ үзүүлэгчдийн эзлэх хувь бусад хоёр дүүргээс илүү өндөр.
- ЧД-ийн нийт ААНБ-ын тоонд үйлдвэрлэл эрхлэгчдийн эзлэх хувь бусад хоёр дүүргийнхээс бага.

Өрхийн амьжиргааг дээшлүүлэх чиглэлд оролцогчид хувиараа бизнес эрхлэх сонирхол бүх дүүргүүдэд давамгайлж байна.



Зах зээлийн судалгааны үр дүнгээс гарсан бүтээгдэхүүнүүдийн тусламжтайгаар МУЗН өрх бүрийн сонгосон бизнест тохирсон 1.5 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн дэмжлэгийг өрхүүдэд олгов.

*Эрэлтийн судалгааны үр дүнгээр зорилтот өрхийн эрхлэхийг хүсэж буй тогтвортой амьжиргааны төрлүүдийг авч үзвэл*



## ЭДИЙН ЗАСГИЙН НОГООН ШИЛЖИЛТ ТӨСЛИЙН СУУРЬ СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ

2023.02 - 2023.03



switchasia



### ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

“Эдийн засгийн ногоон шилжилт” (SOGE) төсөл нь Монгол улсын хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд 22.7%-аар бууруулах Парисын хэлэлцээрт өгсөн амлалтыг биелүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилготой бөгөөд Монгол Улсын газар тариалангийн гаралтай хүнс, ус, ундаа үйлдвэрлэлийн салбарт хэрэгжиж буй Европын холбооны Свич Эйшиа (SWITCH-Asia) хөтөлбөрийн анхны төсөл юм.

Тус төслийг Пипл ин Нийд (ПИН) ОУТББ, Каритас Чех Репаблик (КЧР) ОУТББ болон Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо (ТоС), Хөгжлийн Шийдэл ТББ-ууд хамтран хэрэгжүүлж газар тариаланд суурилсан хүнс, ус, ундаа үйлдвэрлэл эрхэлдэг бичил, жижиг, дунд үйлдвэрлэгчид (БЖДҮ), борлуулагчдыг дараах арга замаар дэмжиж ажиллах төлөвлөгөөтэй байгаа юм. Үүнд:

- Хүнс, ус, ундааны салбарын БЖДҮ, борлуулагч нарыг салбартаа тогтсон хэв загвараа илүү ногоон болгон өөрчлөхөд нь шаардлагатай техникийн туслалцаа үзүүлэх, эко шошгожуулалтыг зах зээлд нэвтрүүлснээр ногоон санхүүжилтэд хүрэх, тойрог эдийн засагт шилжихэд нь туслах
- Хөдөө аж ахуй, хүнс, ундааны салбарын БЖДҮ, борлуулагчид өртгийн ногоон сүлжээ бүхий тойрог эдийн засгийн мэдлэг,

чадвар, туршлагатай болсноор өөрийн бараа үйлчилгээг баталгаажуулах, эко шошго авах боломжтой болно.

- БЖДҮ болон борлуулагч нар ногоон баталгаажуулалт, эко шошго авахад туслах цахим платформ хөгжүүлж, баталгаажуулах үйлчилгээг үзүүлнэ.
- Ногоон баталгаажуулалт, эко шошгыг одоогийн цахим төлбөрийн болон урамшууллын системүүдтэй холбоно.
- Зан дадлын өөрчлөлтийг нэвтрүүлэх зорилготой ногоон баталгаажуулалт, эко шошгыг сурталчлах аян явуулна.

Энэхүү төслийн хүрээнд манай байгууллага хөдөө аж ахуйд суурилсан хүнс, ус, ундаа үйлдвэрлэгч нийт 300 бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчид болон жижиглэн худалдаа эрхлэгчдээс компьютерт суурилсан утсаар мэдээлэл цуглуулах арга (CATI)-ыг ашиглан тойрог эдийн засаг, эко шошгололтын практикт дасан зохицох мэдлэг, өнөөгийн нөхцөл байдлын талаарх суурь мэдээллийг цуглуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Мэдээлэл цуглуулалтыг Улаанбаатар хот болон Эрдэнэт, Сэлэнгэ аймгийн бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хамруулан 2023 оны 2-р сард зохион байгуулав.



## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ШААРДЛАГАТАЙ ҮЙЛЧИЛГЭЭ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАР ХҮРЭЭ, ДЭМЖЛЭГИЙН ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА

2023.10 - 2023.12



### ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн Газар (МУЗГ)-аас эдийн засгийг төрөлжүүлэхээр хөдөө аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээг өргөжүүлэх, түүнчлэн аялал жуулчлал, хөнгөн үйлдвэр болон эрчим хүчний салбарыг хөгжүүлэх чиглэлд хүчин чармайлт гаргаж байна. Энэхүү санаачилгын хүрээнд Эдийн Засгийн Хөгжлийн Яам (ЭЗХЯ)-аас Германы Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-тай хамтран “**Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих**” (PROGRES) төслийг 2021 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Уг төсөл нь гурван чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаагийн нэг нь эдийн засгийн хөгжил, хөрөнгө оруулалтыг дэмжих бүтцийг бэхжүүлэх үйл ажиллагаа юм.

Энэ үйл ажиллагааны хүрээнд манай хүрээлэн ЭЗХЯ-ны харьяат Хөрөнгө Оруулалт Худалдааны Газрын цаашдын үйл ажиллагааг төлөвлөх, хөрөнгө оруулагчдад үзүүлж буй үйлчилгээний чанар болон хүртээмжийг сайжруулах зорилгоор “**Хөрөнгө оруулагчдад шаардлагатай үйлчилгээ, үйл ажиллагааны цар хүрээ, дэмжлэгийн хэрэгцээг тодорхойлох суурь судалгаа**”-ны мэдээлэл цуглуулалтын ажлыг хийж зохион байгууллаа.

Судалгаанд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын төлөөлүүдийг хамруулсан бөгөөд мэдээлэл цуглуулалтыг 2023 оны 10 сараас 12 сарын хооронд хийж гүйцэтгэсэн юм.

# ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ) нь төсөл, хөтөлбөр, бодлогын явц, үр нөлөөг үнэлэх, хянах, тасралтгүй сайжруулахад тусалдаг системчилсэн үйл явц бөгөөд IRIM-ийн хамгийн өндөр чадавхтай, мэргэшсэн үйл ажиллагааны нэг чиглэл юм. ХШҮ-ний төслүүд IRIM-ийн хэрэгжүүлж буй нийт төслийн 35 орчим хувийг дангаар эзэлдэг ба бид ХШҮ-ний төслүүдээрээ дамжуулан хөгжлийн салбарт хэрэгжиж буй төслүүдийг **хэрэгцээнд нийцсэн, үр дүнтэй, үр ашигтай, үр нөлөөтэй, тогтвортой** хэрэгжихэд нь дэмжлэг үзүүлэхийг зорин ажилладаг. Бид ХШҮ-г хяналт шалгалт, аудит гэж хүлээж авах уламжлалт хандлагыг бэхжүүлэхээс зайлсхийж, төсөл хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах процесс, сургамж туршлагаа дүгнэх системийн нэг хэсэг болохынх нь хувьд оролцогч талуудад таниулах, ач холбогдлыг нь ойлгуулж, **үр дүнд суурилсан (result-based), олон талын оролцоонд суурилсан (participatory-based M&E methods)** аргачлалуудаар зохион байгуулахыг эрмэлздэг.



## ГИШҮҮНЧЛЭЛ



Салбар, сэдэв, төслийн үйл ажиллагаа, үр шим хүртэгч талуудаас хамааран ХШҮ-г гүйцэтгэхдээ оролцогч талуудын хэв маяг, онцлогт тохируулан оролцогчийг нууцалсан аргууд (anonymous survey, interview)-ээс эхлүүлэн Аалзны тор, Асуудлын мод, Н-форм, Картын арга зэрэг олон талт үнэлгээний аргуудыг уламжлалт болон дижитал хэлбэрээр ашиглан мэдээллээ цуглуулдаг. Сүүлийн үед олон нийтийн оролцоонд суурилсан шинэлэг аргууд болох Дүрс зургийн арга (Photovoice), оролцоот бичлэгийн арга (Participatory video) -дыг ХШҮ-ний төслүүдэд ашиглаж, арга зүйгээ улам баяжуулсаар байна.

**Явцын үнэлгээ (Process Evaluation)** нь хөгжлийн төсөл хөтөлбөрүүдэд ашиглаж буй арга зүй, дизайн нь үр нөлөөтэй байгаа эсэхийг нягталж, үйл ажиллагаагаа сайжруулахын тулд шинэчлэл, өөрчлөлт хийхэд шаардлагатай мэдээллийг гаргаж өгч, төслийн зорилт, төлөвлөгөөг эргэн харж, сайжруулах боломжийг олгож байдаг. Явцын үнэлгээг гүйцэтгэхдээ бид *'Явцыг мөшгөх (Process Tracing)'* буюу хийгдсэн үйл ажиллагаа, ажилбаруудыг эргэн мөшгөх аргачлал болон *'Өөрчлөлтийн онолын зураглал (Mapping in Theory of Change)* зэрэг аргачлалуудыг голлон ашиглаж байна.

**Үр нөлөөний үнэлгээ (Impact evaluation)** нь аливаа төсөл хөтөлбөрийн үр дүнд бий болсон үр дагавар, үр нөлөөг илрүүлж, тодруулахыг зорьдог. Өөрсдийн хүчин чармайлтын үр дүнд бий болж буй өөрчлөлтүүдийг ойлгосноор асуудлын уг шалтгааныг таньж, илүү үр нөлөө бий болгож буй санаачилгууд руу нөөцөө хуваарилах боломжийг олгодог. Үр нөлөөний үнэлгээний хүрээнд, *'Үр дүнгийн ургац хураах арга (Outcome Harvesting)'*, *'Нийгмийн сүлжээний дүн шинжилгээ (Social Network Analysis)* зэрэг аргачлалуудыг ашиглаж байна.

**Гүйцэтгэлийн үнэлгээ (Performance Evaluation)** нь аливаа төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааны ахицыг хүлээгдэж буй үр дүн, урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтүүдийн дагуу тооцдог. Аливаа гарч буй ахиц дэвшил болон үр дүнгийн талаар нотолгоог бий болгосноор оролцогч талуудын дунд итгэлцлийг бий болгож, ил тод, хариуцлагатай байдлыг дэмжиж өгдөг.

**Форматив үнэлгээ (Formative evaluation)** нь аливаа төсөл, хөтөлбөрийн *төлөвлөлт болон хэрэгжилтийн шатанд хийгддэг* бөгөөд төслүүдийн давуу, сул тал, боломж, сорилтуудыг илрүүлэх замаар суралцах, сайжруулах боломжийг олгож өгдөг. Гол оролцогч талуудаас сайжруулалт, өөрчлөлт хийх санал зөвлөмж, санал бодлуудыг тусгах замаар өөрсдийн бий болгохоор зорьж буй үр дүндээ хүрэх арга барил, аргачлалаа тодорхойлж авахыг зорьдог. Форматив үнэлгээний хүрээнд *'Оролцоом үйл ажиллагааны судалгаа (Participatory action research)'*, *'Оролцоом үнэлгээ (Participatory evaluation)'*, *'Олон нийтийн нөөцийн зураглал (Community mapping/asset mapping)'*, *'Асуудлын мод (Problem tree)* зэрэг аргачлалуудыг ашиглаж байна.

**Самматив үнэлгээ (Summative evaluation)**-г аливаа төсөл хөтөлбөрийн төгсгөлд гүйцэтгэдэг бөгөөд төслийн алдаа, сургамжийг тодорхойлохоос гадна ажлын үр дүн, үр нөлөөг үнэлэхэд голлон анхаардаг. Аливаа санаачилгуудын урт хугацааны үр дүнг үнэлснээр цаашид ижил төстэй ажлуудыг хэрэгжүүлэх стратеги, арга барилаа сайжруулж чаддаг. Уг үнэлгээнд, *'Үр дүнгийн зураглал (Outcome mapping)'*, *'Үр дүнгийн ургац хураалт (Outcome harvesting)'*, *'Delphi' техник (Delphi technique)* болон *'Санамсаргүй Хяналттай Туршилт (A randomized controlled trial)'*-ын аргачлалуудыг нийтлэг ашиглаж байна.

ХШҮ-ний төслүүд нь бусад судалгааны төслүүдээс илүү бие даасан, нотолгоонд суурилсан шинжтэй байж, үнэлгээний багаас мэргэжлийн бөгөөд хөндлөнгийн байр суурь, анализ хийх чадавхыг ихээр шаардаж байдаг. Иймд бид ХШҮ-ний ур чадвараа ахиулахын тулд үндэсний, бүс нутаг, олон улсын мэргэжлийн үнэлгээчдийн холбоо, сүлжээнд гишүүнээр идэвхтэй ажиллаж, баг, мэргэжилтнүүдийнхээ ХШҮ-ний чадавхыг тасралтгүй сайжруулахад анхааран ажилладаг. Тухайлбал бид:

- 2016 оноос хойш Ази-Номхон Далайн Үнэлгээний Холбоо (Asia Pacific Evaluation Association)-ны гишүүнээр ажиллаж байгаа бөгөөд үнэлгээний туршлагаа хуваалцаж, бүс нутгийн сайн туршлагуудыг идэвхтэй нэвтрүүлэх замаар Монгол Улсдаа болон бүс нутагтаа үнэлгээний дадлуудыг сайжруулахад хүчин чармайлт гарган ажиллаж байна.
- 2017 онд Монголын Үнэлгээний Сүлжээ (Mongolian Evaluation Network)-г санаачилсан бөгөөд одоогоор IRIM нь нарийн бичгийн үүрэг гүйцэтгэж байгаагийн хувиар Ази-Номхон Далайн Бүсийн Үнэлгээний Стратеги болон олон улсын үнэлгээний стандартуудыг нэвтрүүлэх, түгээх үүрэгтэйгээр ажиллаж байна.
- Мөн IRIM-аас Хөгжлийн Үнэлгээний Сургалтын Олон Улсын Хөтөлбөр (IPDET)-д жил тутам тогтмол судлаачдаа хамруулан өөрсдийн үнэлгээний мэдлэг, туршлагаа тасралтгүй бэхжүүлсээр байна.



## СУРГУУЛИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙН 5 ДУГААР ШАТНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТЫН ҮНЭЛГЭЭ

2023.01 - 2023.05



БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН ЯАМ



THE WORLD BANK  
IBRD • IDA | WORLD BANK GROUP



### ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улсын хэмжээнд бага боловсролын салбарт боловсролын чанар, сурлагын ахиц, дэвшлийг үнэлэх болон сургалтын амжилтад, чадварт нөлөөлдөг зүйлсэд чиглэсэн ажлууд, багш нарын хамтын ажиллагаа дутмаг зэрэг нөхцөл байдалд үндэслэн энэхүү төслийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага бий болжээ. Энэхүү бага боловсролын нөхцөл байдал, тулгамдсан асуудалд үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ)-аас Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр 2015 оны 8 дугаар сараас эхлэн “**Боловсролын чанарын шинэчлэл төсөл**” (БЧШТ)-ийг бага боловсролын эх хэл ба математикийн сургалтыг дэмжих замаар бага боловсролын чанарыг ахиулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор хэрэгжүүлж байгаа юм.


Уг төслийн бүрэлдэхүүн хэсэг 3-ын хүрээнд бага боловсролын сургалтын чанарыг сайжруулах, сургалтын хэрэглэгдэхүүнийг баяжуулахад чиглэсэн шинэлэг үйл ажиллагааг дэмжих зорилгоор БШУЯ-аас төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын санаачилсан төслийн саналыг шалгаруулан тэтгэлэг олгох

үйл ажиллагаа буюу “Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийг (СТХ)” 2016-2021 оны хооронд С1, С2, С3, С4, С5 гэсэн үсгийн товчлол бүхий нийт 5 үе шатны тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Үүний хүрээнд IRIM судалгааны хүрээлэн нь “Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 5 дугаар шатны хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт хийх” үнэлгээний ажлыг Баян-Өлгий, Дорнод, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий, Улаанбаатар (9 дүүрэг) хотод 2023 оны 1 дүгээр сараас 5 дугаар сарын хооронд хэрэгжүүлсэн.

### ЗОРИЛГО, ЗОРИЛТ

“Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 5 дугаар шатны хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт хийх” үнэлгээний зорилго нь

- СТХ-ийн 5 дугаар шатны хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт хийх,
- Төслийн үр шим хүртэгчдийн сэтгэл ханамжийн түвшнийг үнэлэх явдал юм. Энэхүү хоёр зорилгын хүрээнд IRIM нь дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан. Үүнд:



## ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 4 дүгээр шат нь сургалтын чанарт ахиц гаргахад чиглэж байсан бол 5 дугаар шат нь мэдээллийн технологийн дэвшлийг ашиглах замаар КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор үүссэн сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах зорилготой байв. Эдгээр шатад хэрэгжүүлсэн төслүүд нь эцэг эхийн оролцоо, хичээлээс гадуурх сургалтыг илүү онцлон авч үзсэн ба БШУЯ-аас баталсан бодлогын баримт бичгүүдтэй уялдаж байсан.

СТХ-ийн удирдлага, нэгдсэн зохион байгуулалтад үнэлгээнд хамрагдсан багш нарын сэтгэл ханамж өндөр байгаа нь СТХ нь нөөцөө үр ашигтай хуваарилж, зохицуулсныг илтгэн харуулна. Өөр өөр түвшинд, олон оролцогч талуудыг хамруулж тэтгэлэг олгосон нь сурагчдын сурлагын чанарт ахиц гаргах, хоцрогдол нөхөх, арилгах асуудлыг системтэйгээр, олон талын оролцоотойгоор, өөр өөр аргачлал бүхий шийдлүүдийг турших, нэвтрүүлэх боломжуудыг нээлттэй олгож өгсөн байна.

Төслийн үр дүн нь хөндлөнгийн үнэлгээ болон сэтгэл ханамжийн шалгуур үзүүлэлтээр хэмжигдсэн. СТХ-ийн 5 дугаар шатанд хамрагдсан сургуулиудын олонх нь төслийн зорилго, зорилтдоо бүрэн хүрсэн үзүүлэлттэй байгаа бөгөөд сургуулиудын олонх нь багшийн заах арга зүй, үр чадварыг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлжээ. Үр шим хүртэгчдийн сэтгэл ханамж өндөр гарсан ба сурагчид, багш нар болон эцэг эхчүүдэд бүгдэд эерэг нөлөө үзүүлсэн байна. Түүнчлэн төсөл нь мэдээлэл технологи, зайнаас суралцах болон контент бэлтгэх зэрэг үр чадваруудыг сайжруулсан.

Тогтвортой байдал нь багш болон сургалтын менежерүүд төслийн үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлж, сайн туршлагаа хуваалцаж буйгаар батлагдав. Төслүүд нь хамтын ажиллагаа болон харилцан суралцах соёлыг бий болгох замаар оролцогч талуудад үр шим өгсөн. Үнэлгээний зөвлөмж хэсэгт үр дүнд нарийвчилсан үнэлгээ хийж, үр дүнтэй арга зүйг түгээн дэлгэрүүлэх, багш нарын санаачилгыг дэмжих, салбарын хүрээнд болон их, дээд сургуулийн оюутнууд болон шинээр ажиллаж буй багш нарт санаачилгыг сурталчлах зэргийг тусгав.

## УСНЫ ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН САНАЛ БОДЛЫН СУДАЛГАА

2023.05 - 2023.09



### ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын хүн ам 30 хүрэхгүй жилийн хугацаанд бараг гурав дахин нэмэгджээ. Үүнийг дагаад Улаанбаатар хотод ундны усны ихээхэн хомсдол үүсэж, нэмэлтээр уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж, оршин суугчдын амьдралын чанарт нөлөөлөх эрсдэл үүсээд байгаа юм. Энэхүү асуудалд үндэслэн Монгол Улсын Засгийн Газар (МУЗГ) болон Мянганы Сорилтын Корпорац (МСК) нь эдийн засгийн өсөлтийг дэмжих замаар ядуурлыг бууруулах зорилгын хүрээнд Мянганы сорилтын хоёр дахь Компакт гэрээнд 2018 оны 7 дугаар сарын 27-ны өдөр гарын үсэг зурав.

Талууд Компакт гэрээний хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх бөгөөд хөтөлбөрийн хүрээнд харилцан уялдаа бүхий дараах гурван томоохон төсөл, үйл ажиллагаанд хөрөнгө оруулж байна. Үүнд:

- Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагаа
- Хаягдал ус дахин боловсруулах үйл ажиллагаа
- Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаа

IRIM судалгааны хүрээлэн нь МСК-ын захиалгаар **"Усны талаарх олон нийтийн санал бодлын судалгаа"**-г зохион байгуулж, нэгтгэн дүгнэх ажлыг 2023 оны 5-аас 9 дүгээр сарын хооронд хийж гүйцэтгээд байна. Энэхүү судалгааны гол зорилго нь Улаанбаатар хотын усны нөөц, хомсдол, хэрэглээний талаарх иргэдийн мэдлэг, ойлголтыг тодорхойлоход чиглэж байна. Мөн судалгааны хүрээнд МСК-аас хэрэгжүүлж буй "Усны төсөл"-ийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг тодорхойлж, төслийн цаашдын мэдээлэл сурталчилгааны стратеги, төлөвлөгөөг боловсруулахад оршиж байв.

## ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Усны талаарх олон нийтийн санал бодлын судалгаагаар дараах 4 зүйлийг тодорхойлох зорилт тавьж ажилласан. Үүнд:

- Улаанбаатар хотын өнөөгийн болон ирээдүйн усны хомсдол, нөөцийн талаарх олон нийтийн санаа бодлыг тодорхойлох,
- Олон нийт усны ач холбогдлыг зөвхөн өрхийн хэрэглээний түвшинд төдийгүй, арилжааны бизнес, үйлдвэрлэлийн эрчим хүч үйлдвэрлэхэд чухал ач холбогдолтой болохыг мэддэг эсэхийг тодорхойлох,
- Усны төсөл, түүний хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх олон нийтийн санаа бодлыг тодорхойлох,

- Эдгээртэй холбоотой мэдлэг дээшлүүлэх чиглэлийн үйл ажиллагаануудад зориулсан санал зөвлөмж боловсруулах.

Судалгаанд Улаанбаатар хотын 6 дүүргийн нийт 2,002 иргэнийг хамруулж тэдний санаа бодлыг нэгтгэн дүгнэж тайланг боловсруулав.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН

Энэхүү судалгаа нь үндсэндээ тоон судалгааны аргад суурилсан ба асуулгыг хаалттай, нээлттэй хариулт авах асуултуудыг хослуулж, тоогоор хэмжигдэхүйц, өөр хоорондоо харьцуулагдахуйц байдлаар бүтэцлэсэн.



## “ЗАЛУУЧУУДЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН КОРПУС” ХӨТӨЛБӨРИЙН ЭЦСИЙН ШАТНЫ ҮНЭЛГЭЭ

2022.10 - 2023.01



Монгол  
Экологи төв



Эх сурвалж: [www.youthcorps.mn](http://www.youthcorps.mn)

### ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Залуучуудын Тогтвортой Хөгжлийн Корпус (ЗТХК) хөтөлбөрийн гол зорилго нь 15-22 насны залууст байгаль орчин, тогтвортой хөгжлийн мэдлэг олгож, хувь хүний хөгжил, ур чадварыг нь дэмжих замаар нийгэмд оролцоотой, хариуцлагатай, байгальд ээлтэй иргэн болгон төлөвшүүлэх юм. Тус хөтөлбөр нь 2019-2023 оны хооронд нийт 10 дэд хөтөлбөр бүхий үйл ажиллагааг Ховд, Өмнөговь, Улаанбаатар хотын байгалийн тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН)-ийн ойр байршилтай зургаан ерөнхий боловсролын сургууль болон үндэсний хэмжээнд өнөөг хүртэл 71 нь сургуулийн нийт 1,539 гаруй хүүхэд залуусыг хөтөлбөрийн үйл ажиллагаанд биечлэн болон цахимаар хамруулсан юм.

### ТӨСЛИЙН ДИЗАЙН

2019-2023 оны хооронд хэрэгжсэн ЗТХК хөтөлбөрийн эцсийн шатны үнэлгээний ажлын хүрээнд i) хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн үйл ажиллагааг үнэлж, ii) хөтөлбөрийн цаашид анхаарах санал, зөвлөмжөөр хангаж ажиллаа.

Үнэлгээг тоон болон чанарын аргыг ашиглан гүйцэтгэсэн. Тодруулбал, чанарын судалгааны хүрээнд 20 ганцаарчилсан ярилцлага болон фокус бүлгийн ярилцлага, тоон судалгааны хүрээнд асуумжийн аргаар 230 түүврийг бүрдүүлж цугларсан мэдээлэлд дүн шинжилгээ хөтөлбөрийн эцсийн үнэлгээг хийж гүйцэтгэв.

### ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

Эцсийн шатны үнэлгээний үр дүнгээс харахад хөтөлбөр нь голлох зорилтууддаа хүрсэн байна. Тухайлбал:

- ЗТХК хөтөлбөр 15-22 насны хүүхэд, залуучуудад байгаль орчноо хамгаалах, байгалийн болон соёлын нөөцийг зохистой ашиглах чиглэлээр мэдлэг, мэдээлэл олж авах боломжийг нэмэгдүүлэх, олон улсын туршлагад суралцаж, улс орны тогтвортой хөгжилд оролцох, хянах, нөлөөлөх чадвар бүхий ирээдүйн иргэнийг бэлтгэх гол зорилгодоо хүрсэн;
- Цогц сургалтуудаар дамжуулан нийгэмд тустай шинэлэг төсөл, дадлагын хөтөлбөрүүдийг бий болгож, хэрэгжүүлэхэд



нь дэмжлэг үзүүлэх ЗТХК платформ байгуулах зорилтот үр дүндээ хүрсэн;

- ТХГН-ын сургууль болон бусад талуудыг чадавхжуулснаар сурагчдын мэдээллээр хангах гэсэн зорилгодоо ерөнхийдөө хүрсэн.

Мөн түүнчлэн ЗТХК-ийн хүрээнд зохион байгуулагдсан олон улсын туршлага судлах аялал нь хамгийн үр дүнтэй үйл ажиллагаануудын нэг байжээ. Дадлагын хөтөлбөрт сурагч, хүүхдүүд хамрагдах сонирхол их, дадлагын хөтөлбөрт хамрагдсанаар олон зүйлийг таньж мэдэхээс гадна хэрхэн шийдвэрлэх шийдлийн олон хувилбарыг олж харсан байна. Түүгээр ч зогсохгүй сурагчид хөтөлбөрөөс зохион

байгуулсан үйл ажиллагаанд оролцож, сурсан мэдсэнээ бусдадаа түгээн, эерэг дам нөлөөг үзүүлж байна.

Хүүхэд, залуучуудад байгаль орчин, тогтвортой хөгжлийн боловсролыг онцлог агуулга, арга зүйгээр хүргэдэг ЗТХК хөтөлбөрийг цаашид үргэлжлүүлэхээс гадна илүү олон сургууль, олон сурагчдад хүрч, өргөжүүлэх хэрэгцээ, шаардлага байна. Үүний тулд хөтөлбөрийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн санхүүжүүлэх эх үүсвэрийг олох шаардлагатайгаас гадна хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, оролцогчдын бүртгэлийн системийг сайжруулах, оролцогч талуудын идэвх, оролцоог дэмжих, урамшуулах зохион байгуулалтыг сайжруулах хэрэгтэй байгаа талаар үнэлгээний үр дүнгээс ажиглагдав.

## “МОНГОЛ УЛС ДАХЬ ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХАД ЧИГЛЭСЭН ХӨГЖЛИЙН АЖИЛД ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ЖИЖИГ ТӨСЛҮҮДИЙГ ДЭМЖИХ САН 2020-2023” ТӨСЛИЙН ЭЦСИЙН ШАТНЫ ҮНЭЛГЭЭ

2023.05 - 2023.06

MISEREOR  
IHR HILFSWERK



CATHOLIC CHURCH  
IN MONGOLIA



### ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

*“Монгол Улс дахь ядуурлыг бууруулахад чиглэсэн хөгжлийн ажилд зөвлөгөө өгөх жижиг төслүүдийг дэмжих сан 2020-2023”*

төсөл нь хөдөө, орон нутгийн болон хотын захын дүүргүүдийн иргэдэд хүмүүнлэгийн, ахуйн, нийгмийн болон оюунлагийн дэмжлэг туслалцаа үзүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулахад чиглэсэн. Төслийн хүрээнд Улаанбаатар хотод (5), Өвөрхангай, Хархорин суманд (4), Дорноговь болон Өмнөговь аймагт (3), бусад орон нутагт (2) зэрэг нийт 14 жижиг төслийг 2020-2023 оны хугацаанд санхүүжүүлэн ажиллажээ.

Германы “MISEREOR” байгууллагын захиалгаар IRIM судалгааны хүрээлэн нь нэг сарын хугацаанд (2023 оны 05-06 сар) энэхүү төслийн эцсийн шатны үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэв.

### ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Энэхүү үнэлгээ нь хөдөө орон нутгийн хөгжлийг дэмжих, ядуурлыг бууруулах, боловсрол, хүмүүнлэгийн дэмжлэг үзүүлэх үндсэн чиглэл бүхий жижиг төслүүдийн үр дүнг үнэлэх замаар *“Монгол Улс дахь ядуурлыг бууруулахад чиглэсэн хөгжлийн ажилд зөвлөгөө өгөх сан”*-аас хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ хийх гол зорилготой байв.

Төслийн ерөнхий үнэлгээг хийхдээ Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Хөгжлийн тусламжийн хороо (OECD-DAC)-ны Үнэлгээний аргачлалыг ашиглан нийт 31 хэрэгжүүлэгчид болон төслийн үр шим хүртэгчдийг хамруулсан. Үнэлгээг 10 хүнийг хамруулсан 2 удаагийн фокус бүлгийн ярилцлага, 21 ганцаарчилсан ярилцлага, кейсэд тулгуурлан боловсруулав.

**ЗОРИЛГО:** Төсөл нь суурь боловсрол олгох, байгаль орчныг хамгаалах, ардчиллыг дэмжих, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хангах, орон нутгийн соёл, уламжлалыг хадгалахад хувь нэмрээ оруулах зорилготой.

01/07/2020 - 30/06/2023

#### ЗОРИЛТ №1

Байгаль орчныг хамгаалах, ялангуяа уул уурхайн салбарын нөлөөлөлд өртсөн бүс нутгуудад арга хэмжээ авах, орон нутгийн уламжлал, ялангуяа уламжлалт анагаах ухааныг сэргээх, орчин үеийн сорилтод дасан зохицоход хувь нэмрээ оруулах

#### ЗОРИЛТ №2

Монгол Улсын улс төр, нийгэм эдийн засгийн өөрчлөлтийг дэмжихэд иргэний нийгэм, ардчилсан хүчнүүдийг бэхжихэд хувь нэмрээ оруулах

#### ЗОРИЛТ №3

Хөдөө орон нутгийн нийгмийн эмзэг бүлгийнхний ирээдүйн шинэ хэтийн төлөвийг нээж өгөх зөвлөгөө, сургалт, чадавхийг бэхжүүлэх арга хэмжээнд хамруулах. Улаанбаатарт шилжин ирэгсэд нийгмийн үйлчилгээнд хамрагдаж, эрхийнхээ талаар мэдээлэлтэй байлгахад хувь нэмрээ оруулах.

## ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

Үнэлгээгээр уг төсөл хэрэгжсэнээр өөрчлөлт гаргаж байгаа эсэх, мөн цаашид энэ төрлийн санаачилгуудыг дэмжих хэрэгцээ байгаа эсэхийг үнэлж, амжилттай үйл ажиллагаа, арга аргачлалуудыг илрүүлэхийг зорьсон.

Төслийн хүрээнд санхүүжүүлсэн 14 төслийн ихэнх нь хөдөө орон нутагт хэрэгжсэн бол Улаанбаатар хэрэгжсэн төслүүд нь хотын захын дүүрэг, бүсэд хэрэгжсэн нь төслийн үндсэн агуулгатай сайтар нийцүүлсэн байна. Эдгээр 14 төслүүдийг төслийн ерөнхий 3 зорилгын хүрээнд захиалагч байгууллагын дэвшүүлсэн зорилтуудаар ангилж үзвэл бүгд төслийн зорилготой нийцсэн байна.

### Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Үнэлгээ	
	Хамтрагч байгууллага	Үр шим хүртэгч
Хамааралтай байдал	4.8	4.5
Тохиромжтой байдал	5.0	5.0
Үр дүнтэй байдал	5.0	4.8
Үр нөлөөтэй байдал	5.0	5.0
Тогтвортой байдал	5.0	5.0

(1 = Муу, 2 = Муу, 3 = Дунд зэрэг, 4 = Сайн, 5 = Маш сайн)

Төслийн үйл ажиллагааг Фокус бүлгийн ярилцлагын үеэр бүхэлд нь 1-10 оноогоор үнэлүүлэхэд хамтрагч талууд 9.25 оноо өгсөн бол үр шим хүртэгчид 9.5 оноо өгсөн. Энэ нь хангалттай сайн гэсэн үнэлгээ бөгөөд үнэлгээний аргачлалын дагуу Хамааралтай байдал, Тохиромжтой байдал, Үр дүнтэй байдал, Үр нөлөөтэй байдал, Тогтвортой байдал гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрээр 1-5 оноогоор үнэлүүлэхэд дараах үр дүн гарсан.

Эдгээр үр дүнг дүгнэвэл төрийн байгууллагын тэр бүр анхаарч чадахгүй байгаа хэсгүүдэд төсөл хэрэгжүүлэгчид ихээхэн хувь нэмрээ оруулж чадсан байна. Эдгээр байгууллагуудын үйл ажиллагааг өргөжүүлэх, нийгэмд үр нөлөөтэй төслүүдийг хэрэгжүүлэхэд MISEREOR нь онцгой хувь нэмэртэй үйл ажиллагааг хэрэгжүүлж чадсан байна.

# УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжлийн сорилтуудыг шийдвэрлэх бидний арга барилын гол тулгуур нь **уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хөгжил (Climate-resilient development)**-ийн аспектийг бүх салбарын судалгаа, ХШҮ-ний төслүүдэд харгалзах явдал юм. Уг ойлголт нь уур амьсгалын өөрчлөлтөд **дасан зохицох (adaptation)**, **сааруулах (mitigation)** арга замуудыг хослуулсан чиг хандлага бөгөөд эдгээр асуудлыг бүх л салбарын бодлого төлөвлөлт, шийдвэр гаргалт, хөрөнгө оруулалтын үйл явцад харгалзсанаар бид уур амьсгалын өөрчлөлтийн эдийн засаг, экосистем, олон нийтэд үзүүлэх нөлөөллийг бууруулж, тэсвэртэй байдлыг бий болгоход өөрсдийн хувь нэмрээ оруулахыг зорьдог.



Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой байдлын чиглэлээр зорилтот төслүүд нь бидний хэрэгжүүлж буй нийт төсөл хөтөлбөрүүдийн 20 гаруй хувийг дангаар эзэлдэг бөгөөд дараах дэд сэдвүүдэд голлон төвлөрч байна:



### **Хүрээлэн буй орчин ба байгаль хамгаалал:**

Монгол орны байгалийн ялгаатай бүс нутгууд, биологийн олон янз байдал нь манай улсын нийгэм, эдийн засаг, соёлын болон хөгжлийн үндэс тул IRIM нь тус салбарт тулгамдаж буй асуудлуудын талаар нотолгоо цуглуулах, түншлэгч талуудын ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, байгаль, цаг уурын өөрчлөлтөд өртөж буй иргэд, олон нийтийн аж амьдралд үзүүлж буй нөлөөлөл, дасан зохицох, даван туулах чадавх, тогтолцоог дэмжихэд чиглэсэн судалгаа, үнэлгээний ажлуудыг гүйцэтгэж ирсэн. Тухайлбал, тусгай хамгаалалтай газар нутгийн менежментийн тогтолцоог бэхжүүлэх, орон нутгийн иргэдийн оролцоотой байгаль хамгааллын тогтолцоог нэвтрүүлэхэд чиглэсэн судалгааны ажлууд нь бидний чадавх бүхий гол талбар юм.

**Уур амьсгалын өөрчлөлт:** Уур амьсгалын чиглэлээр бид Парисийн хэлэлцээр, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр, Үндэсний дасан зохицох төлөвлөгөөний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, нотолгоонд суурилсан мэдээллээр талуудыг хангах, мэдээллийн уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулахад төвлөрөн ажиллаж байна. 2022 онд бид *“Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх иргэдийн мэдлэг, хандлага, дадал хэвлэл мэдээллийн хэрэглээний судалгаа”*-г үндэсний хэмжээнд зохион байгуулсан бөгөөд уг үр дүнд үндэслэсэн иргэд, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх кампанит ажлуудыг Даян Дэлхийн Хөгжлийн Институт үндэсний хэмжээнд зохион байгуулж байна.

Мөн уур амьсгалын чиглэлээр салбар бүрд хийгдэж буй судалгааны ажлуудыг уялдуулах, судлаач, мэргэжилтнүүдийн мэдээлэл солилцоог нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор 2023 онд IRIM Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хөгжлийн асуудлыг судалдаг судлаач мэргэжилтнүүд дунд *“Судлаачдын бүлгэм/Community of Practice”*-ийг эхлүүлсэн. Цаашид энэхүү судлаачдын нэгдлээр дамжуулан уур амьсгалын салбарын судалгааны үр дүнгүүдийг хэлэлцүүлж, шийдэлд чиглэсэн бодлогын хэлэлцүүлгүүдийг өрнүүлэхээр зорьж байна.

Мөн НҮБ-аас уур амьсгалын асуудлаар жил тутам зохион байгуулдаг COP 2023 оны 28 дахь чуулганаас Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл дэх хүнсний тогтолцоо болон эрүүл мэндийн салбарын асуудалд онцгойлон анхаарахаар амлалт өгч, холбогдох бичиг баримтуудад нэгдэхээ илэрхийлсэн.

Энэ чиглэлд хувь нэмэр оруулахуйц салбарын бэлэн байдлыг сайжруулахад чиглэсэн (1) “Уур амьсгалын өөрчлөлтийн хүний эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлд үзүүлэх нөлөөлөл”-ийн үнэлгээ, (2) “Эрүүл мэндийн салбарт ажиллагсдын уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, хандлага, дадал болон эрүүл мэндийн байгууллагын уур амьсгалын өөрчлөлт дэх бэлэн байдлын судалгаа”-нуудыг манай байгууллага ЭМЯ, Даян Дэлхийн Хөгжлийн Институттэй хамтран хэрэгжүүлж байна.

**Тойрог эдийн засаг ба ногоон хөгжил:** Дэлхий нийтээр байгалийн баялгийг үр ашигтай, хаягдал багатайгаар эдийн засгийн эргэлтэд оруулахыг чухалчилж, нөөцөөр бүтээгдэхүүн үйлдвэрлээд, хэрэглээд хаядаг шугаман эдийн засгаас татгалзаж, нөхөн сэргээгдэх тойрог загварыг илүүд үзэж байна. Тойрог эдийн засгийн ойлголт Монголын нөхцөлд харьцангуй шинэ тутам ойлголт бөгөөд тодорхой салбар чиглэлүүдэд уг ойлголтыг бодлого, эрх зүйн баримт бичгийн түвшинд нэвтрүүлэх, турших оролдлогууд идэвхтэй явагдаж байна. Манай байгууллагын хувьд 2022-2025 оны хугацаанд “Аялал жуулчлалын салбарын жижиг дунд бизнес эрхлэгчдийн тойрог эдийн засгийн чиглэлээр чадавхжуулах” төслийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон АХБ, Тогтвортой санхүүжилтийн холбоо, Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд аялал жуулчлалын салбарт тойрог эдийн засгийн концептийг нэвтрүүлэх замын зураглал (policy roadmap) боловсруулж, ЖДБЭ-ийг чадавхжуулах өргөн хүрээтэй үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

**Ил тод, хариуцлагатай уул уурхай:** Орон нутгийн хөгжил, эдийн засагт уул уурхайн оруулж буй хөрөнгө оруулалтыг оновчтой чиглүүлэх, нөгөө талаас уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй орон нутгийн иргэдийн аж байдал, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох, талуудын байр суурийг нийгэмд эн тэнцүү хүргэхэд чиглэсэн уул уурхай, олборлох салбарын судалгааны ажлууд бидний туршлага бүхий үйл ажиллагааны үндсэн чиглэлийн нэг.

Энэ чиглэлд бид Уул уурхай хүнд үйлдвэрийн яам болон Оюу толгой ХХК, Энержи Ресурс зэрэг хувийн хэвшлийн төлөөллүүд, UNDP, GIZ, AMEP олон улсын байгууллагууд, тэдний хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд болон их сургуулиуд, мэргэжлийн ассоциаци, холбоо, нийгэмлэгүүдтэй идэвхтэй хамтран ажиллаж байна.

## МОНГОЛ УЛСАД УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНД, ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХООЛ ТЭЖЭЭЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

2023.05 - 2024.04



### ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Дэлхий дахин уур амьсгалын өөрчлөлттэй нүүр тулж, үүнийг дагасан цаг уурын өөрчлөлтүүд (хэт халалт, цочир хүйтрэлт, г.м.)-ээс шалтгаалсан эрүүл мэндийн сөрөг нөлөөллүүд анхаарал татахуйц хэмжээнд хүрээд байна. Дэлхийн дунджаас 2-3 дахин илүү хурдтай дулаарч буй Монгол орны хувьд ч мөн уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан эрүүл мэндийн сөрөг үр дагаврууд нэмэгдсээр байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн цөлжилт, газрын доройтол хүрээгээ тэлэхтэй зэрэгцэн Монгол орны газрын гадаргын хэв шинж ихээр өөрчлөгдөж байна. Үүнээс шалтгаалсан шороон шуурга хүн амын эрүүл мэндэд нөлөөлж, ялангуяа амьсгалын замын өвчлөлийг нэмэгдүүлэхэд хүрчээ.

Цаг уурын эрс тэс байдал нэмэгдэх нь цөлжилт, бэлчээрийн доройтлыг даамжруулж, ургацын хэмжээ багасахад нөлөөлж, улмаар шим тэжээл бүхий дотоодын хүнсний хангамж буурах эрсдэлийг улам нэмэгдүүлж байна. Цаашид уур амьсгалын өөрчлөлтийн хүний эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдалд үзүүлж буй нөлөөллийн талаар илүү нарийвчлан судлах, хариу арга хэмжээ авах тогтолцоог нэвтрүүлэх, шинэ болон сэргэж буй халдварт өвчний

хамаарлыг судлах, халдварт өвчний онцлогийг харгалзан хүн амыг хамгаалах арга хэмжээг зохион байгуулах хэрэгцээ шаардлага үүсэж байгаа юм.

### ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Монгол Улсын хэмжээнд агаарын хэмийн өөрчлөлт болон цаг уурын бусад хүчин зүйлс хүн амын нас баралт, цаашлаад сонгосон өвчлөлд хэрхэн нөлөөлөх нөлөөтлийг судлан тогтоож, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг нийгмийн эрүүл мэндийн дасан зохицох бодлогод дэмжлэг болохуйц нотолгоонд суурилсан зөвлөмж боловсруулахад энэхүү судалгааны зорилго оршино. Судалгааг манай хүрээлэн 2023 оны 5 дугаар сараас 2024 оны 4 дүгээр сарын хооронд гүйцэтгэж байна.

### ТӨСЛИЙН ДИЗАЙН

Энэхүү судалгаанд тоон болон чанарын аргуудыг хослуулан ашигласан. Амьсгалын тогтолцооны өвчин, Зүрх судасны тогтолцооны өвчин, Хоол боловсруулах тогтолцооны өвчин, малаас хүнд халдах өвчин, нас баралт гэсэн 5 бүлэг өвчлөлийн 2012-2022 оны хоорондох 10 жилийн сар тутмын өгөгдөл мэдээлэлд

Өвчлөлийн нэрс	Хувьсагчууд	Эх сурвалж	Хугацааны интервал	ICD-10 код	Давтамж
Амьсгалын тогтолцооны өвчин	Шинэ тохиолдлын тоо	ЭМХТ	2012-2022	J00-J99	Сараар
Зүрх судасны тогтолцооны өвчин				I00-I99	
Хоол боловсруулах тогтолцооны өвчин				K00-K93	
Малаас хүнд халдах өвчин				A84 A20	
Нас баралт (амьсгалын тогтолцооны, зүрх судасны тогтолцооны, нийт хорт хавдар)				I00-I99 J00-J99 C00-D48	

шинжилгээ хийж, цаг уурын 12 экстремаль индексүүдтэй харьцуулах замаар хамаарлыг тодорхойлсон. Мөн эрүүл мэндийн салбарын гол оролцогч талуудтай ганцаарчилсан ярилцлага зохион байгуулж мэдээлэл цуглуулсан.

### Цаг уурын бодит ажиглалтын мэдээлэл

Тус судалгаанд цаг уурын 30 гаруй станцын 2012-2022 оны агаарын температур, хур тунадас, салхи, чийгийн мэдээллийг ашиглаж байна.

Өртөнги байдал нь уур амьсгалын экстремаль утгуудаас шууд хамаардаг. Байгаль, нийгэм эдийн засгийн салбаруудын эрсдэл, нөлөөллийн үнэлгээ хийхэд агаарын температур, хур тунадасны экстремаль индексийг өргөнөөр ашигладаг. Дэлхийн цаг уурын байгууллагын CCI/CLIVAR ажлын хэсгийн гаргасан ClimPACT

программ хангамжийг (<http://etccdi.pacificclimate.org/software.shtml>), (Zhang & Feng, 2004) ашиглан хөдөө аж ахуй, гадаргын ус, хүний эрүүл мэндэд нөлөө үзүүлэх уур амьсгалын 80 гаруй экстремаль индексүүдээс агаарын температур, хур тунадасны 12 индексийг сонгон авч тооцоолол хийж байна. Сонгон авсан хур тунадасны экстремаль индексийн тодорхойлолтыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Цаг уурын зарим хүчин зүйлс буюу уур амьсгалын экстремаль индексүүд нь хүн амын зарим өвчлөл, нас баралтад хэрхэн нөлөөлж буйг судлан тогтоож уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой нийгмийн эрүүл мэндийн дасан зохицох бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх нотолгоонд суурилсан зөвлөмж гаргахаар ажиллаж байна.

### Уур амьсгалын экстремаль индексийн тодорхойлолт

Товчлол	Индекс нэр	Тодорхойлолт	Нэгж	Нөлөөлөх салбар
Температурын индекс				
F0	Хүйтэн өдөр	Хоногийн минимум температур 0 градусыг давж хүйтэрсэн өдрийн тоо	хоног	хөдөө аж ахуй, эрүүл мэнд
SU30	Халуун өдөр	Хоногийн максимум температур 30 градусыг давж халсан өдрийн тоо	хоног	хөдөө аж ахуй, эрүүл мэнд
Tx10p	Сэрүүн өдөр	Хоногийн үнэмлэхүй их температур 10%-ийн хангамжтай байсан өдрийн тоо	хоног	Ус, хөдөө аж ахуй, эрүүл мэнд
Tx90p	Халуун өдөр	Хоногийн үнэмлэхүй их температур 90%-ийн хангамжтай байсан өдрийн тоо	хоног	Ус, хөдөө аж ахуй, эрүүл мэнд
Tn10p	Сэрүүн шөнө	Хоногийн үнэмлэхүй бага температур 10%-ийн хангамжтай байсан өдрийн тоо	хоног	Ус, хөдөө аж ахуй, эрүүл мэнд
Tn90p	Халуун өдөр	Хоногийн үнэмлэхүй бага температур 90%-ийн хангамжтай байсан өдрийн тоо	хоног	Ус, хөдөө аж ахуй, эрүүл мэнд
WSDI	Халуун өдрийн үргэлжлэх хугацаа	Хоногийн үнэмлэхүй их температур 90%-ийн хангамжтай байсан өдөр 6 ба түүнээс дээш хоног дараалан ажиглагдсан өдрийн тоо	хоног	Ус, хөдөө аж ахуй, эрүүл мэнд
Хур тунадасны индекс				
RX1day	Нэг хоногийн хамгийн их тунадас	Хоног ажиглагдсан хамгийн их хур тунадасны хэмжээ	мм	Ус, хөдөө аж ахуй, эрүүл мэнд
RX5day	Тав хоногийн хамгийн их тунадас	5 хоногт ажиглагдсан хамгийн их хур тунадасны хэмжээ	мм	Ус, хөдөө аж ахуй, эрүүл мэнд
SPEI12	Цаг уурын ган буюу хуурайшилт	12 сараар тооцоолсон хур тунадасны стандартчилагдсан индекс		Ус, хөдөө аж ахуй, эрүүл мэнд

## ОРОН НУТГИЙН ИРГЭДТЭЙ УТГА УЧИРТАЙ ОРОЛЦОО БИЙ БОЛГОХ НЬ


2023.12



### ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

IRIM судалгааны хүрээлэнгээс Оюу Толгой ХХК-ийн Орон нутгийн харилцааны багт зориулан “Орон нутгийн иргэдтэй утга учиртай харилцаа холбоо бий болгох нь” нэг өдрийн сургалтыг 2023 оны 12 сард Өмнөговь аймагт зохион байгуулав. Уг сургалтад Оюу толгой компаниас 20 оролцогч, Оюу толгойн хөгжлийн хурдасгуур сангаас 5 оролцогч нар тус тус хамрагдсан. Энэхүү сургалт нь дараах зорилгын хүрээнд зохион байгуулагдлаа.

- IRIM судалгааны хүрээлэнгийн Өмнөговь аймагт хийгдэж байсан уул уурхай, олон нийтийн санаа бодол, орон нутгийн харилцааны чиглэлийн судалгаануудын онцлох үр дүнг танилцуулах,
- Орон нутгийн харилцааны сүүлийн үеийн олон улсын чиг хандлагын талаар мэдээлэл, мэдлэг хуваалцах,
- Оролцоонд суурилсан бүлгийн хэлэлцүүлгээр дамжуулан харилцан суралцах зорилгын хүрээнд зохион байгуулагдав.





# “ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ МӨРДӨН ШАЛГАХАД АНХААРАХ АСУУДАЛ” СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ

2023.05 - 2023.06



## ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Ханнс-Зайделийн сан нь Экологийн Цагдаагийн албаны мөрдөгч, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгаль хамгаалагч нарын мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгын хүрээнд “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгахад анхаарах асуудал” сэдвээр 2023 оны 5 болон 6 сард нийт 4 удаагийн цуврал сургалтуудыг зохион байгуулсан.

Уг сургалтуудад төвийн болон зүүн бүсэд байршилтай 10 аймгийн (Хөвсгөл, Архангай, Баянхонгор, Өмнөговь, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Дархан) 68 төрийн албан хаагч хамрагдсан ба нэг удаагийн сургалт нь 2 өдрийн турш зохион байгуулагдсан.

## ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Манай хүрээлэн нь уг сургалтын үнэлгээг гүйцэтгэсэн бөгөөд уг ажлын хүрээнд сургалтад оролцогчдын мэдлэг, ур чадвар нь сургалтын өмнө болон дараа хэрхэн өөрчлөгдсөнийг үнэлэх болон үүний үр дүнд үндэслэн цаашид зохион байгуулах сургалтуудыг сайжруулах зөвлөмжийг боловсруулах зорилготой ажиллаа.

## ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

Экологийн цагдаа нарт хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн талаарх мэдлэг, байгаль хамгаалагч нарт зөрчлийн тухай агуулга бүхий сургалтуудыг зохион байгуулсан. IRIM судалгааны хүрээлэн нь сургалтуудын өмнө болон дараа нь оролцогчдын мэдлэгийн өөрчлөлтийг шалгах зорилгоор ижил агуулга бүхий тест авч сургалтын үр ашигтай байдлыг үнэлэв.

Үр дүнгээс харахад Экологийн цагдаагийн албан хаагчдын мэдлэг сургалтын өмнөх үнэлгээ (32.6%)–ээс (55.3%) болж нэмэгдсэн бөгөөд бүх агуулгаар мэдлэгийн ахиц гарсан нь ажиглагдсан. Мөн байгаль хамгаалагч нарын мэдлэг ерөнхий дунджаараа сургалтын өмнөх үнэлгээ (58.9%) болж нэмэгдсэн ч зарим нэг агуулгаар мэдлэгийн түвшин буурсан тохиолдол ажиглагдсан. Экологийн цагдаа нарын мэдлэг хамгийн ихдээ (46.0%) хүртэл нэмэгдсэн бол байгаль хамгаалагч нарын мэдлэг хамгийн ихдээ (36.8%) хүртэл нэмэгдсэн нь эерэг үр дүн болж байна.

Судалгаанд оролцогчдын мэдлэгийн өөрчлөлт, %



# ХӨГЖИЛ

Өнгөрсөн 16 жилийн хугацаанд бид хөгжлийн салбарт боловсрол, жендэрийн тэгш байдал, нийгмийн хамгаалал, нийгмийн эрүүл мэнд, хот, хөдөөгийн хөгжил зэрэг үндсэн чиглэлүүдээр бүс нутаг болон үндэсний хэмжээний судалгаа, үнэлгээг амжилттай гүйцэтгэж ирсэн. Ингэхдээ бид хөгжлөөс **"хэнийг ч орхигдуулахгүй байх"** зарчмыг эрхэмлэж, нийгмийн ялгаатай бүлгүүдийн асуудал, хэрэгцээ, сонирхлыг таниулах, хүн бүрд тэгш боломжийг бий болгоход хувь нэмрээ оруулахыг зорин ажиллаж байна.

Бидний төвлөрөн ажилладаг хөгжлийн салбар, чиглэлүүдийг танилцуулбал:



## ГИШҮҮНЧЛЭЛ



ЖЕНДЭРИЙН  
ҮНДЭСНИЙ ХОРОО

ISA International  
Sociological  
Association

専修大学  
SENSHU UNIVERSITY

Give2Asia

**Нийгмийн сайн сайхан байдал:** 2016 оноос хойш бид **"Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа"**-г эхлүүлж, нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүр тасралтгүй гүйцэтгэж байна. Уг судалгааны гол зорилго нь нийгмийн нягтрал, итгэлцэл, аз жаргал зэрэг субъектив сайн сайхан байдлын үзүүлэлтүүдийг шинжлэх ухааны суурьтайгаар судалж олон нийтэд таниулах, шийдвэр гаргалтад нийгмийн капиталын үзүүлэлтийг харгалздаг болох чиглэлээр нөлөөлөл үзүүлэх явдал юм. 2017 оноос хойш манай байгууллага "Олон улсын Нийгмийн сайн сайхан байдлын судалгааны консорциум"-д гишүүнээр ажиллаж байгаа бөгөөд консорциумаас зохион байгуулдаг бүсийн болон олон улсын хурлуудад оролцож, илтгэлээ хэлэлцүүлж, эрдэм шинжилгээний бүтээл хамтран боловсруулах, судалгааны төсөл хэрэгжүүлэх байдлаар идэвхтэй хамтын ажиллагаатай байдаг. Түүнчлэн Олон Улсын Социологичдын Холбоонд (ISA) 2010 оноос хойш Монгол Улсыг төлөөлөн албан ёсны гишүүнээр ажиллаж байгаа ба тус байгууллагаас батлан гаргасан "Ёс зүйн дүрэм"-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг.

**Боловсрол:** Бид боловсролын чанар, хүртээмжийн асуудлаар бага болон дунд сургуулийн хүрээнд, боловсрол ба хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар дээд болон тусгай мэргэжлийн боловсролын хүрээнд судалгаа, зөвлөх үйлчилгээний ажлуудыг голлон гүйцэтгэдэг. Сүүлийн жилүүдэд Дэлхийн Банк, НҮБ-ын Хүүхдийн сан, Японы Хүүхдийг Ивээх Сан зэрэг олон улсын байгууллагууд, БШУЯ, ХНХЯ зэрэг төрийн байгууллагуудтай хамтран тэгш хамран сургах боловсролын асуудлыг онцгойлон судалж, шийдвэр гаргалтыг дэмжихэд шаардлагатай нотолгоонд суурилсан мэдээллүүдийг бүрдүүлэн ажиллаж байна. Боловсролын чиглэлээр дагнан гүйцэтгэсэн ажлууд нь бидний нийт хэрэгжүүлсэн төслийн 10 орчим хувийг эзэлдэг.

**Жендэр, зорилтот бүлгийн асуудал:** Бид 2017 оноос хойш тасралтгүй 7 дахь жилдээ Жендэрийн Үндэсний Хорооны сайн дурын гишүүнээр ажиллаж байгаа бөгөөд Монгол Улс дахь жендэрийн тэгш байдал, салбаруудын жендэрийн бодлого, төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ зэрэг зорилтот төслүүдийг хэрэгжүүлж ирсэн өргөн туршлагатай. Мөн зорилтот төслүүдээс гадна бусад салбарын судалгааны төслүүддээ жендер, хөгжлийн бэрхшээл, нийгмийн эмзэг бүлгийн төлөөллийг тэгш хамруулах **GEDSI approach (Gender Equality, Disability and Social Inclusion)**-ыг баримтлан, жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг үйл ажиллагаандаа харгалзан (gender mainstreaming) ажиллаж байна. Тухайлбал, бид бүх салбарын судалгаанд өгөгдөл, мэдээллийг хүйсээр ялган шинжилж, хүйсийн ялгаатай байдал, онцлогоос хамаарсан үр дүн бий эсэхийг тодруулж, судалгааны дүгнэлт зөвлөмждөө тусган ажилладаг.

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хүчирхийлэл, гэмт хэргийн хохирогчид, бэлгийн цөөнх, хэл соёл угсаатны цөөнх, алслагдмал хороо, сумын иргэд, шилжин ирэгсэд зэрэг хүрч ажиллахад хүндрэлтэй нийгмийн онцлог бүлгүүдийн эрх ашгийг тусгайлан хөндсөн олон тооны судалгаа, үнэлгээний төслүүдийг хэрэгжүүлсэн туршлагатай. Бид хүний эрхийн судалгаануудыг гүйцэтгэхдээ хүн-төвтэй арга хандлагыг (**human-centered approach**) баримталдагас гадна, олон улсад нэр хүнд бүхий **The Collaborative Institutional Training Initiative (CITI Program)**-ээс олгодог **Research, Ethics, Compliance, and Safety Training**-д судлаачдаа

хамруулж, хүний эрх, эрхэм чанар, нэр төртэй холбогдох судалгааны ажлууддаа уг стандартын зааварчилгааг чанд мөрдөж ажилладаг.

**Нийгмийн эрүүл мэнд:** Энэ хүрээнд Монгол Улсад хэрэгжиж буй нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн бодлого, хөтөлбөрүүдийг үнэлж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, ялгаатай бүлгүүдийн эрүүл мэндийн боловсрол, дадал, зан байдлыг судалж, хүний эрүүл мэндэд нөлөөлж буй гол хүчин зүйлүүдийг тодорхойлоход чиглэсэн судалгааны төслүүдийг хэрэгжүүлж ирсэн.

Эрүүл мэндийн судалгааны ажлуудыг гүйцэтгэхдээ манай хүрээлэн ЭМЯ, Анагаахын шинжлэх ухааны их сургууль, Ач анагаах ухааны их сургуулийн **Эрдмийн зөвлөл болон Ёс зүйн хороо**-нд судалгааны арга зүй, аргачлалаа танилцуулж, баталгаажуулалт авах практикийг мөрддөг.

Мөн бид зөвхөн судалгааны төслүүд хэрэгжүүлэхээс гадна гамшгийн үед эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжих хариу арга хэмжээний төслүүдийг санаачлан хэрэгжүүлдэг. Тухайлбал, 2020, 2021 онуудад Give2Asia олон улсын хандивын сүлжээнээс хөрөнгө босгож **"COVID 19-ийн нөлөөнд өртсөн зорилтот бүлгийн иргэдэд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх төсөл"**-ийг хэрэгжүүлж, нийт 400 гаруй эмзэг бүлгийн өрхөд шууд тусалцаа үзүүлэх филантропи ажлыг хэрэгжүүлж байсан туршлагатай.

**Хот, хөдөөгийн хөгжил:** IRIM нь орон нутгийн хөгжил, хотжилт, олон нийтийн оролцооны асуудлаар судалгаа, шинжилгээ гүйцэтгэж ирсэн арвин туршлагатай. Бид судалгааны ажлуудаараа дамжуулж дэд бүтцийн хөгжил, хотжилтын динамик, хөдөөгийн амьжиргаа, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой олон төрлийн бүлгүүдэд тулгамдаж буй сорилт, бэрхшээлүүдийг тодорхойлж, тэдгээрт тохирсон шинэлэг гарц, боломжуудыг эрэлхийлэн, хот, хөдөөгийн тогтвортой хөгжлийг бий болгоход өөрсдийн хувь нэмрийг оруулахыг зорьдог.

IRIM нь газар зүйн туршлагын хувьд 21 аймгийн бүх 330 суманд хүрч мэдээлэл цуглуулалт хийж байсан туршлагатай бөгөөд уг туршлагадаа тулгуурлан бүс нутгийн, улирлын болон үндэсний цөөнх, нүүдэлчин, малчин өрхүүдийн соёлын онцлогийг харгалзан талбарын зохион байгуулалтыг төлөвлөж ажилладаг.

# ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САНГИЙН 2024-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

2023.10 - 2024.05



ГОВИЙН ОЮУ  
ХӨГЖЛИЙГ  
ДЭМЖИХ САН



## ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

IRIM нь Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан (ХДС-ийн)-ийн ирэх 5 жилийн Стратегийн төлөвлөгөөг боловсруулах зөвлөх үйлчилгээг 2023 оны 10 дугаар сараас 2024 оны 05 дугаар сар хүртэл үзүүлж байна. Манай байгууллага нь эхний стратегийн баримт бичиг болох 2018-2021 онд баримтлах стратеги, үндсэн чиглэлийг тодорхойлж боловсруулах зөвлөх үйлчилгээг 2017-2018 онд хэрэгжүүлсэн ба дараагийн таван жилийн стратеги чиглэлийг боловсруулах ажилд дахин шалгарч хамтран ажиллаж байна.

Говийн Оюу хөгжлийг дэмжих сан нь 2015 онд үүсгэн байгуулагдаж, Өмнөговь аймаг, тус аймгийн Ханбогд сум болон “Оюутолгой” ХХК (ОТ)-ийн хооронд байгуулсан 3 талт Хамтын ажиллагааны гэрээ (ХАГ)-ний хэрэгжилтийг хангах зорилготой төрийн бус байгууллага юм. Уг гэрээ нь сэдэвчилсэн 7 хавсралтын хүрээнд

буюу (i) усны менежмент, (ii) байгаль орчны менежмент, (iii) мал аж ахуй, (iv) түүх соёл, аялал жуулчлал, (v) нийгмийн суурь үйлчилгээ, (vi) орон нутгийн бизнес хөгжлийг дэмжих, (vii) дэд бүтэц, хөрөнгө оруулалтын чиглэлээр жил бүр ОТ ХХК-аас олгох 5.0 сая доллар түүнтэй тэнцэх төгрөгийн сайн дурын санхүүжилтийг олгож, удирдан зохион байгуулж, Өмнөговь аймагт тогтвортой үр ашиг авчрах төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэн орон нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахаар тохиролцсон байдаг.

Өмнөх стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн хугацаа дуусаж, дээрх сэдэвчилсэн хавсралтын дагуу шинээр баримтлах Стратегийн төлөвлөгөө 2024-2028-ыг боловсруулах зөвлөх үйлчилгээ нь дараах гурван үндсэн үе шатаас бүрдэж байна.

### ҮЕ ШАТ 1

Өмнөх стратегийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх түргэвчилсэн үнэлгээ



### ҮЕ ШАТ 2

ХАГ-ний сэдэвчилсэн хавсралтуудын дагуу хэлэлцүүлэг зохион байгуулах



### ҮЕ ШАТ 3

Стратегийн баримт бичгийг боловсруулах, батлуулах

## ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

ХДС нь 2015-2023 онд 122.88 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 108.8 тэрбум төгрөг буюу 88.54% нь төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд зарцуулагдсан гэж дурджээ.

Зөвлөх үйлчилгээний дээрх 3 үе шатанд дараах үр дүнгүүдийг гаргаад байна.

**Өмнөх стратегийн түргэвчилсэн үнэлгээ:** Энэхүү үйл ажиллагаа нь өмнөх Стратегийн хэрэгжилтийн үр дүнг үнэлснээр дараагийн таван жилд баримтлах стратеги, үндсэн чиглэлийг боловсруулахад анхаарах асуудлыг тодруулах гол зорилготой байв. Үнэлгээг гүйцэтгэхдээ өмнөх таван жил болох 2018-2022 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны гүйцэтгэлийг авч үзсэн. Үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэхдээ байгууллагын тайлан, мэдээлэл болон ажилтнууд, харилцагчид, хэлэлцүүлгийн оролцогчид зэрэг олон талын байр сууринаас үнэлэлт, дүгнэлт өгсөн.



2018-2022 онд санхүүжүүлсэн 74.4 тэрбум төгрөгийн 284 төсөл, хөтөлбөрт үнийн дүн болон тоогоор ангилан дүн шинжилгээ хийхэд дараах үр дүн харагдаж байна.

Нийт төсөл, хөтөлбөрийн 68.4%-ийг нийгмийн дэд бүтэц, хөрөнгө оруулалтын төслүүд, үлдсэн 31.6%-ийг тогтвортой хөгжлийн төслүүд эзэлжээ. Эдгээр төсөл, хөтөлбөрийн тоог

харьцуулж үзвэл нийгмийн суурь үйлчилгээний чиглэлийн төслүүдийг дэмжсэн байна. Харин байгаль орчны менежментийн чиглэлийн төслүүд үнийн дүн болон хэрэгжсэн тоогоор хамгийн бага байна. Тиймээс цаашид үнийн дүн болон тоогоор бага хэрэгжсэн чиглэлд анхаарал хандуулах шаардлагатай байна.

Хамтрагч талууд Говийн-Оюу ХДС-тай хамтарсан хамтын ажиллагааны үр дүнг 1-5 оноогоор үнэлэхэд (1-маш муу, 5-маш сайн) **ерөнхийдөө сэтгэл ханамжтай** буюу байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалтыг 4.19, үндсэн чиглэлүүдийн хэрэгжилтийг 4.0 гэж үнэлсэн байна. Мөн ХДС-тай хамтран ажиллахад ямар нэгэн хүндрэл тулгараагүй гэж судалгаанд оролцсон хамтрагч талуудын 86% нь хариулсан.

Говийн Оюу ХДС-ийн стратегийн зорилгод *"Санхүүжүүлэгч, харилцагч байгууллагууд болон иргэдийн итгэлийг хүлээсэн тогтвортой сан байна"* гэж тодорхойлсон тул хамтрагч талуудын итгэлийн индексийн түвшнийг 2018 оны суурь үзүүлэлттэй харьцуулж үзсэн. Үр дүнд нь ХДС-д итгэх итгэл нэлээд өндөр гэсэн **ерөнхий үр дүн гарсан ба 8.3-8.9** (0-10 хүртэлх оноо) болон нэмэгдсэн байгаа нь сайшаалтай үр дүн болж байна. Гэхдээ сангийн мэдээлэл, хүртээмжийг сайжруулах шаардлага байгаа нь олон талын үнэлгээгээр харагдаж байгаад анхаарах хандуулах хэрэгтэй.



**Сэдэвчилсэн хавсралт тус бүрээр хэлэлцүүлэг зохион байгуулах:** Говийн Оюу Хөгжлийг дэмжих сангийн ирэх 5 жилд баримтлах үйл ажиллагаа, төлөвлөгөөний үндсэн чиглэлийг боловсруулахад иргэд, мэргэжилтнүүдийн санал, дуу хоолой, хүсэл эрмэлзлийг тусгахад чиглэсэн. Сэдэвчилсэн 7 хавсралт тус бүрээр холбогдох талуудын төлөөллийн оролцоог хангахыг чухалчилж, төрийн болон иргэдийн гэх мэт олон талын оролцоо, дуу хоолойг аймгийн болон сумдын түвшинд хангаж оролцохыг эрмэлзсэн. Хэлэлцүүлэг тус бүрийг 20-40 оролцогчтойгоор зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн үндсэн хэсэг ерөнхий 4 хэсгийн хүрээнд өрнөв.



Хэлэлцүүлэг тус бүрд тухай сэдэвчилсэн чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх мэдээлэл эхний хэсэгт хүргэж, оролцогчдоор үнэлүүлсэн. Дараагийн хэсэгт тухайн чиглэлд хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг тодорхойлж, эрэмбэлэх, эдгээр ажлуудыг хэрэгжүүлэхэд гол оролцогч талуудыг тодорхойлох ажилбаруудыг хийсэн. Хэлэлцүүлгийн үр дүнд гарсан асуудлуудыг ирэх таван жилд анхаарах чиглэлийн суурь болгон ашиглах мэдээлэл болгон холбогдох тайланг бэлтгэсэн.

**Стратегийн баримт бичиг боловсруулах:** Өмнөх стратегийн хэрэгжилтийн үнэлгээ, талуудын шаардлагатай асуудлыг шийдвэрлэх санал санаачилга зэргийг харгалзан 2024-2028 онд баримтлах стратегийн баримт бичгийг эхний хувилбарыг боловсруулаад байна. Одоогоор уг стратегийн баримт бичиг нь 8 стратегийн зорилт, 30 үндсэн чиглэл, 96 үйл ажиллагаанаас бүрдэж байна. Цаашид стратегийн баримт бичгийг ХДС-ийн шат шатны удирдлага болох Харилцааны хороо болон Удирдах зөвлөлд танилцуулж, батлуулах ажлууд үргэлжилж байна.

# ЗУДЫН ҮЕИЙН, ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТҮРГЭВЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ

2023.06 - 2023.08



## ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улс нь алслагдмал газар зүйн байршил, эмзэг экосистем, байгаль цаг агаараас хамааралтай байдал, эдийн засгийн тогтолцоо зэргээсээ шалтгаалан уур амьсгалын өөрчлөлтөд нэн өртөмтгий орон. Сүүлийн 40 гаруй жилийн дотор дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны улмаас Монгол орны экосистем мэдэгдэхүйц өөрчлөгдөж, цөлжилт, ган зудын давтамж ихсэх, усны нөөц, биологийн олон янз байдал хомсдох зэргээр илэрч байна.

Монгол Улсад 1921 оноос хойш 27 удаагийн их бага хэмжээний зуд тохиолдож байв. Говийн аймгуудад хоёроос дөрвөн жил тутамд, улсын хэмжээгээр 13 жил орчимд нэг удаа зуд болж байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс улбаалан ган, зуд, аадар бороо, мөндөр, хүчтэй цасан болон шороон шуурга, уруйн үер зэрэг байгаль цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлүүд, тэдгээрийн давтамж, эрч хүч нэмэгдэж, улмаар осол, эндэгдэл мэдэгдэхүйц өссөн. Эдгээр үзэгдлийн нийгэм, эдийн засагт учруулах хор хохирлын хэмжээ сүүлийн 20 гаруй жилд хоёр дахин нэмэгджээ.

1944 оноос хойш хийсэн судалгаагаар манай оронд болсон зудын нөлөөгөөр нэг жилийн дотор ихдээ ес, багадаа нэг сая орчим толгой мал хорогдож байсан ба энэ нь тухайн жилд тоологдсон нийт малын тооны 2-33 хувийг эзэлж байв. Сүүлийн 30 жилд гэхэд л нийт 21.1 сая толгой мал хорогдож, 860 тэрбум төгрөгийн хохирол учирчээ.

Гамшгийн үед нийгмийн эмзэг бүлгийн өрхийн гишүүд хүчирхийлэлд өртөмтгий байдаг учраас тэднийг хамгаалах асуудлыг дэлхийн дахинд чухалчлан авч үздэг. Энэ ч үүднээс “Дэлхийн Зөн Монгол” ОУБ-ын дэмжлэгтэйгээр IRIM судалгааны хүрээлэн “Зудын үеийн, жендэрт суурилсан хүчирхийллийн нөхцөл байдлын түргэвчилсэн үнэлгээ”-г 2023 онд зуд болсон газар, тэр дундаа “Дэлхийн Зөн Монгол” ОУБ-ын хүмүүнлэгийн тусламж дэмжлэг авсан Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Увс, Завхан, Хэнтий, Хөвсгөл аймгуудын 14 сумын малчид болон холбогдох оролцогч талуудыг хамруулан хийж гүйцэтгэлээ.

## ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Зудад өртсөн өрхүүд, түүн дотроо газар зүй, соёл, уламжлалаар ялгагдах ялгаатай Казах, Тува, Цаатан, бусад угсаатны цөөнх гэр бүлүүдэд тулгамдсан хамгааллын асуудлыг үнэлж, байгалийн гамшигт үзэгдлийн үед үзүүлэх хамгааллын үйлчилгээнд буй зөрүүг шинжлэх зорилготой байв.

Түргэвчилсэн үнэлгээг дараах агуулгын хүрээнд хийж гүйцэтгэсэн бөгөөд дан ганц зудын үеийн бус, жендэрт суурилсан хүчирхийллийн үе дэх эмзэг байдлыг харгалзан авч үзсэн. Мөн энэхүү эмзэг нөхцөл байдлын үед дан ганц эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудал бус тэдний нас, байршил, мэдээллийн хүртээмж зэрэг хүн ам зүй, нийгмийн шинжийг харгалзан үзсэн.



## ҮНЭЛГЭЭНИЙ АГУУЛГЫН ХҮРЭЭ

Түргэвчилсэн үнэлгээний мэдээллийг тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан цуглуулсан.



### Баримт бичгийн шинжилгээ

- Төслийн хүрээнд гүйцэтгэсэн ажлуудын баримт бичиг
- Гамшгийн үеийн ЖСХ-ийн эсрэг хариу арга хэмжээний туршлага болон тулгамдаж буй асуудлыг илрүүлэх үнэлгээ, судалгааны аргачлалууд
- ЖСХ болон гамшгийн үе дэх тусламж, дэмжлэгийн хууль, эрх зүйн зохицуулалт, бодлого, хөтөлбөрүүдийн баримт бичгүүд судалсан.



### Гол талуудын ярилцлага

- Орон нутгийн төлөөлөл болох 12 голлох оролцогч талуудтай ганцаарчилсан ярилцлага зохион байгуулсан.



### Фокус бүлгийн ярилцлага

- Малчид буюу зудад өртсөн өрхийн төлөөллүүдийг хамруулсан 3 удаагийн ФБЯ зохион байгуулсан.



### Асуулга (биечилсэн болон утсан)

- Төсөлд хамрагдан үр шим хүртсэн болон зудад өртсөн 382 малчин өрхүүдээс биечилсэн болон утсан хэлбэрээр тоон судалгааны мэдээлэл цуглуулсан.



### Кейс судалгаа буюу тохиолдлын шинжилгээ

- Зудад өртсөн өрхүүдээс орон нутгийн оролцогч талуудын мэдээлэлд түшиглэн ЖСХ-д өртөх эрсдэлтэй, өртөж байсан эмэгтэйчүүдийг сонгож, 3 кейс судалгааг тус тус хийж гүйцэтгэсэн.



## ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

- Монгол Улсад ЖСХ-ээс сэргийлэх, хамгаалах мөн, байгалийн гамшгийг даван туулах чиглэлийн эрх зүйн зохицуулалтуудыг тус тусад нь үүсгэсэн бөгөөд боломжит механизм, үйлчилгээнүүд хоорондын уялдаа холбоо байхгүй байна. Тухайлбал, энэ хоёр нөхцөл байдал хавсарсан гамшгийн үед ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хамгаалах тогтолцоо, нөөц зарцуулж буй байдал хангалтгүй байна. Ялангуяа, гамшгийн үед ЖСХ-ийг илрүүлэх үзлэг оношилгоо, үйлчилгээ үзүүлэх талаарх нарийвчилсан зааварчилгаа, удирдамж хангалтгүй байна.
- Зудад өртсөн малчдаас ЖСХ-ийн талаарх ойлголт, хандлагыг тодруулахад олонх нь (79.8%) огт мэдэхгүй, сонсож байгаагүй, зөвхөн сонсож байсан буюу энэ талаарх ойлголт, мэдлэг хангалтгүй байна. Тэр дундаа боловсрол багатай, 45-аас дээш насны эрэгтэйчүүдийн дунд түгээмэл байна.
- Зудын үед нийт малчдын (15.9%) буюу 61 малчин сэтгэл санаа, бие махбодын хүчирхийлэлд өртсөн нь гамшгийн бус үетэй харьцуулахад 3 дахин их байна. Өрхийн түвшинд бий болсон өөр нэг нөлөө нь суурь үйлчилгээ авч чадахгүй байх тохиолдол юм.
- Зудын үеэр малчин өрхийн 38 хүүхэд (үүнээс хөвгүүд 20, охид 18) гэр бүлдээ туслах шаардлагатай болсон, хүргэж өгөх хүн байгаагүй, явах зам хаагдсан зэрэг шалтгаанаас сургуульдаа явж чадаагүй байна.

- Мөн, эрүүл мэндийн суурь хэрэгцээнээс шаардлагатай эм тариа (45.3%), ариун цэврийн хэрэгслэлүүд (35.8%) зарим талаар болон огт хангагдаагүй хувь өндөр байна.
- Малчдын (67.3%) нь орон нутагт ЖСХ-д өртөх эрсдэлтэй, өртсөн тохиолдолд хандах үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, хамгаалах байр, сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр зөвлөгөө өгөх 1800-2000 утасны талаар мэдэхгүй байв.

Орон нутгийн хамтарсан багууд эрсдэлт бүлгийн судалгаа гаргах, мэдээллийг тогтмол шинэчлэх, тэдэнд хүрч очиж үйлчилгээ үзүүлэх арга зам, шаардлагатай материаллаг болон санхүүгийн нөөцийг урьдчилан тооцох хэрэгтэй байна. Түүнчлэн олон улсын төрийн бус байгууллагууд гамшгийн үед ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх чиглэлээр нэгдсэн арга зүйн удирдамжийг салбар тус бүрийн онцлогийг харгалзан боловсруулахад техникээр туслах хэрэгцээ харагдаж байна. Ялангуяа, зудын үеийн, сэтгэл зүйн хямралыг даван туулах талаар зөвлөгөө, мэдээллийг бэлтгэн хүргэх, мэргэжлийн сэтгэл зүйчдийг утсаар зөвлөгөө өгөхөд чадавхжуулж, хамтран ажиллах боломж байна. Мөн ЖСХ-ийн талаар малчдын мэдлэг дутмагаас хүчирхийллийг хүлцэн тэвчих хандлага ажиглагдаж байсан. Энэ нь шаардлагатай тусламжийг хаанаас, хэрхэн авах, мэдээлэх талаар мэдлэг, мэдээлэл хомс байгаатай холбоотой байж болзошгүй.

## МОНГОЛ УЛСЫН КОМПАНИУДЫН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА БА ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

2023.07 - 2023.11



### ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү судалгаа нь компаниудын нийгмийн хариуцлага буюу тогтвортой хөгжил (ТХ), байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын хүрээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлдэг бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийг тодорхойлох зорилготой байв. Судалгааны арга зүйн дагуу чанарын аргуудыг ашигласан бөгөөд 2022 оны сүүлээр Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ)-ээс зарласан шилдэг 100 ААНБ-уудын мэдээлэлд үндэслэн түүврийн жагсаалтыг бүрдүүлсэн. Үүнд (1) Баримт бичгийн шинжилгээ, (2) Хагас бүтэцлэгдсэн ярилцлага судалгааны аргуудыг ашиглан мэдээлэл цуглуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Судалгааг гүйцэтгэхдээ байгууллагуудын веб хуудас, байгууллагын үйл ажиллагааны хэвлэмэл тайлан зэрэг нээлттэй тайлагнасан мэдээ зэрэг нийт 72 баримт бичиг, материалуудыг нэгтгэн баримт бичгийн шинжилгээ, биечлэн ярилцлага өгөхийг зөвшөөрсөн 19 ААНБ-тай чанарын ярилцлага тус тус хийж, үр дүнг нэгтгэн дүгнэж судалгааны тайланг боловсрууллаа.

### ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

Нийгмийн хариуцлагын хүрээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр компаниудын хийж буй үйл ажиллагаануудыг байгаль орчин, нийгэм, эдийн засаг гэсэн 3 чиглэлд ангилан авч үзсэн.



**Байгаль орчны чиглэлээр** КНХ-ын хүрээнд МУЗГ, Ерөнхийлөгчөөс санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэх, хот суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр компаниуд ихээхэн анхаарал хандуулж байна. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх нь байгаль орчин, агаарын бохирдолд эмзэг, өртөмтгий нийгмийн бүлгүүд болох хүүхэд, жирэмсэн болон бага насны хүүхэдтэй ээжүүд, ахмад настай иргэдийн амьдрах орчныг сайжруулах болон нийгмийн талаасаа зорилтот бүлгийн иргэдийн дунд түр ажлын байрыг дэмжих ач холбогдолтой юм.



**Нийгмийн чиглэлд** компаниудын нийгмийн хариуцлагын хүрээнд хөрөнгө оруулж буй нэн тэргүүний салбар нь эрүүл мэнд байна.

Амьжиргааны түвшин доогуур, эмзэг бүлгийн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, ахмад настны эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг шийдэх, урьдчилан сэргийлэх болон оношлоход шаардлагатай тоног төхөөрөмж хандивлах, санхүүжилтийг олгох ажлуудыг ихээр

дэмждэг байна. Мөн боловсролын чиглэлээр боловсролын тэгш, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн боловсролд хамрагдалтыг дэмжих, сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, боловсролын инновацыг дэмжсэн санаачилгуудад компаниуд ихэвчлэн хөрөнгө оруулалт хийж байна.



**Эдийн засгийг дэмжих чиглэлээр** тэргүүлэгч компаниудын дунд эмэгтэй эзэнтэй ЖДҮ-ийг дэмжих санаачилгууд нийтлэг байна.

Ялангуяа банкны салбарт ногоон, хөнгөлөлттэй зээлийн үйлчилгээнд эмэгтэй бизнес эрхлэгч нарыг хамруулах, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн сургалт, ур чадвар олгох үйл ажиллагааг компаниуд нийгмийн хариуцлагын хүрээндээ дэмжиж хэрэгжүүлжээ.

Одоогийн байдлаар компаниудын хувьд нийгмийн хариуцлагын бодлогыг боловсруулан үйл ажиллагаандаа ашиглаж буй байдал хангалтгүй байна. Тэргүүлэх топ-72 компаниудын вэб сайтаар зочилж холбогдох мэдээллийг шүүхэд 8 байгууллагын нийгмийн хариуцлагын бодлого л нээлттэй байсан.

Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаагаа тайлагнах байдал, компанийн тоо (n=72)



Нийгмийн хариуцлагын бодлогын хүрээнд туссан үйл ажиллагааны үндсэн чиглэлийг авч үзвэл боловсрол, эрүүл мэнд, байгаль орчин, ЖДҮ эрхлэгчдийн асуудлыг чухалчилсан байдлаар авч үзэж байна. Нийгмийн хариуцлагын бодлого тодорхойлсон байдлын хувьд уул уурхай болон банк санхүүгийн салбар тэргүүлж байна.